

ДЭМЧИГИЙН БУДДАРЬ (1894-1939): НАМТАР, СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ, ЭРДЭМ СУДЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС

У.ЭРДЭНЭБАТ¹, Д.ЭРДЭНЭБАТ²

¹МУИС-ийн НШУС-ийн Археологи-Антропologийн тэнхим,
e-mail: u_erdenebat@yahoo.com

²ШУА-ийн Түүхийн хүрээлэн,
e-mail: daagii1019@yahoo.com

Түлхүүр үгс: Дэмчигийн Буддарь, Буддарь багш, Димчиков, Дэмчигон, Жон Димчиоф, 1920-30-аад оны үеийн монгол сэхээтнүүд, Судар бичгийн хүрээлэн, Багшийн сургууль, Монголын үндэсний палеонтологи, археологийн судалгаа, Эндрюсийн экспедици, 1920-иод оны сүүлчээр Германд сурч байсан монголчууд, 1937 оны хэлмэгдүүлэлт

ТОВЧ АГУУЛГА: XX зууны эхэн үеийн Монголын шилдэг сэхээтний нэг Дэмчигийн Буддарь (1894-1939) багш бол манай эх орны үндэсний палеонтологи ба археологийн шинжилгээ хөгжих үндсийг тавьж, холбогдох эд зүйлсийг цуглуулан, улсын сан хөмрөгт оруулж явсан, Монголын эртний судлалын шинжлэх ухааны тулгын чулууг тулалцсан гавьяатны нэг болох юм. Энэхүү өгүүлэлд Д. Буддарь агсны намтар, сурган хүмүүжүүлэх, эрдэм судлалын үйл ажиллагааны тухай архивын баримт, тухайн үеийн хүмүүсийн дуртгал зэргийг түшиглэн сурвалжлан тодруулахыг зорьсон байна.

1990-ээд оны эхэн үе. Хуучнаар Хувьсгалын Музей буюу тэр үед дөнгөж шинэчлэн зохион байгуулагдаж байсан Монголын Үндэсний Түүхийн Музейн археологийн сан хөмрөгт бидний хэдэн оюутан эртний судлалын хичээлийн дадлага хийж байв. Дээр үед Голын Музей гэж байхад анх эх сууриа тавьж, дараа нь Улсын Төв Музейн үзмэрт тавигдаж явсан элдэв олдворын цуглуулга, зарим нь бүр олон сар жил нар салхи үзээгүй бололтой, тоос шороонд дарагдаж, хуучирч шарласан цаасан боодолтойгоо байж билээ. Энэ завшаанд Бельгийн хүн судлалын ухааны нэрт эрдэмтэн, доктор Хайбальмансад Ринчен гуай илгээж шинжлүүлж байсан гэдэг “алмасын” гавал, Оросын археологич, профессор Киселевийн манай Хархорумаас малтаж гаргасан ваар шаазан зэрэг элдэв төрлийн ховор сонин олдворыг анх удаа биетээр ойроос үзсэн юм. Үүний зэрэгцээ олон улсын хэмжээнд нэрд гарсан алдартай олдворуудаас дутахааргүй бидний сонирхлыг соронзон мэт татаж, гайхал бишрэл төрүүлсэн зүйл гэвэл мөнөөх боодлыг нь задлаагүй хуучны олдворууд байв. Цаасан боодлынх нь дугтуй дээр балын харандаагаар “Будадари. 24 он” гэж хуучин монгол үсгээр таталган бичсэнийг үсэглэн уншаад задлан үзвээс цөм ногоон, шар, хүрэн, хар өнгө алагласан хас, мана, цахиураар үйлдсэн чулуун зэвсгийн олдворууд

байв. Тэр дунд ямар нэг алдаатай гэмээр юмуу өөлөхөөр сонголт хийсэн зүйл нэг ч алга, жинхэнэ мэргэжлийн археологичийн түвшинд хийсэн гайхалтай сайхан цуглуулга байлаа. Чингэж бид анх 1920-30-аад оны үед Монгол эх орондоо мэргэжлийн археологичийн түвшинд, тэр дундаа эртний судлалын нилээд хүнд хэцүү салбарын нэг болох чулуун зэвсгийн судалгаа хийж байсан Буддарь хэмээгч монгол судлаачтай эчнээ танилцаж намтар түүхээс нь тодруулж мэдэх юмсан гэсэн чин хүсэлтэй болсон билээ.

Буддарь бол уг гарал буриад монгол хүн. 1894 онд тэр үеийн Хаант Орос Улсын Чита мужийн бүрэлдэхүүнд багтсан Агын буриадын Цүүгэл нутагт Угсаахай гэдэг газар мэндэлжээ. Эцэг нь Дэлгэрийн Дэмчиг (Зураг 1). Гулбаа буюу буриад зоны сонгуулиар өргөмжлөгдсөн нутгийн тэргүүн ноён, одоогийнхоор бол сумын дарга явжээ. Тэднийх зургаан хүүхэдтэй байснаас Юндэн, Буддарь, Ойдов-Аанчиг нарын гурван хүүтэй. Буддарь Дэмчигийн зургаан хүүхдийн дөрөв дэх нь бөгөөд бусдаасаа илүү ухаалаг сэргэлэн боловч малын ажилд жаахан дөр муутай, үргэлж ном шагайж суудаг хүүхэд байснаас ч тэр үү эцэг нь хүүгээ багаас нь эрдэм номтой хүн болгох зорилго тавьж орос гимназид суралцуулан төгсгөсөн байна.

1917 оны Октябрийн хувьсгалын өмнө хойно буриад зоны нэг хэсэг байгалийн гай гамшиг, дайн дажины самуурлаас болж аж төрж амь зуухын төлөө өнөөгийн Монгол улсын хилийн дотогши нүүдэллэн орж ирэхэд, Дэмчигийнх 1913 оны орчим одоогийн Дорнод аймгийн Халх гол сумын нутаг, газар нутаг өргөн уудам, эх баялаг элбэг дэлбэг нутагт ирж суусан бололтой. Буддарь багшийн тухай бичсэн нийтлэл, дуртгалд тэмдэглэснээр, эцэг нь түүнд Оросын гимназийг онцсайн дүнтэй төгсгөөд ирэхэд нь далан амбан шар өмчилж өгөөд “хаа боломжтой газар очиж эрдэм сур” хэмээн захисан ажээ.

Ингээд Буддарь хүү эцгийн захисан ёсоор эрдэм сурах алс холын аян замд гарч үхрээ туусаар Өвөр Монголын нутагт орж иржээ. Олон шар үхэр туусан, буриад дээл хувцастай, аяншиж ядарсан Буддарь хүүг өвөрлөгч нутгийн зарим хүмүүс “энэ лав Ар Монголоос мал хулгайлаад хил давуулан худалдахаар яваа шилийн хулгайч байх” хэмээн сэжиглэн хардаж барьж аваад хошуу тамгын газраа хүргүүлжээ. Хүүгийн аз таарахад хошууны ноён шударга сайн хүн таарч, үнэн учраа ололцоод, түүнийг ер хулгайч хүний маяггүй тул суллан тавьж, улмаар үхэр шараа зарж борлуулан бэлтэй болоход нь тусалсан гэдэг.

Буддарь хүү зардал мөнгөтэй болоод тэндээсээ цааш явж Дундад Иргэн Улсын нийслэл Бээжин хотод очиж хятад хэл бичиг үзсэн ба улмаар Харбин хот дахь генерал Хорватын нэрэмжит Төмөр замын институтэд суралцан төгсгөсөн байна. Буддарь хүү тэндээсээ Хонгконг, Шанхайд очиж үргэлжлүүлэн суралцахын зэрэгцээгээр нэг хэсэг оройн цагаар ачаа ачигчаар ажиллаж явжээ. Тийн явахдаа бум бужигнаж түм түжигнэсэн Шанхай хотын боомтод нэгэн япон залуутай дотно танилцаж нөхөрлөсөн ажээ. Тэгээд хөлөг онгоцоор тэр япон найзыгаа даган Наран улсад очиж япон хэл бичигт шамдан суралцсан байна.



*Зураг 1. Буддарь багшийн эцэг Дэлгэрийн Дэмчиг.
XIX-XX зууны зааг үе. Манжуурт авахуулсан гэрэл зураг.*

Энэ урт замд дутагдах гачигдахын элдэв бэрхшээл тохиолдовч Буддарь тэр болгоныг даван туулахын тул биеийн хүчний янз бүрийн ажил ч хийж явжээ. Жишээ нь тэр, Японд байхдаа багшидаа өгөх сургалтын зардлаа олохын тулд хөлсний тэрэгчин буюу чухамдаа хүн тэрэг болон зөөвөр хийж явсан ч удаатай гэдэг. Тийнхүү Буддарь англи, хятад, япон хэл бичиг, байгалийн шинжлэх ухааны

талаар чамлахааргүй мэдлэгтэй болж цаашид өөр улс оронд очиж суралцах бэлтгэл юугаан хангаад Филиппин оржээ. Тэндээсээ Буддарь Америк орж нэг эргээс нь нөгөө эрэг хүртэл хөндлөн гулд, явган нүцгэн туулсан гэдэг бөгөөд улмаар Америкаас Францад, Францаас Германд очиж суралцаад эцэст нь 1920-иод оны эхэн үест Германаас Монголдоо ирсэн байна.

Буддарь эх орондоо эргэн ирсний дараа шинэ цагийн Монголын шинжлэх ухааны төв байгууллага Судар бичгийн хүрээлэнд судлагчаар орж ажилласан баялангуяа эрдэм шинжилгээний талаар гадаадтай харьцах ажилд чухал үүрэг гүйцэтгэж байв (Чойжамц, 1996). Ийнхүү эрдэм сурахаар дэлхийг тойрч, орчин цагийн соёл боловсролын шимийг хүртэж, орос, англи, герман, франц, хятад, япон хэл бичигт боловсорсон залуу монгол сэхээтэн Буддарь эх орныхоо боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжилд хүчээ өргөх үйлсээ эхэлжээ. Буддарь багшийн эцэг Дэмчиг нь “Би энэ хүүгээ ганц үг дуугарахад нь улс амьтан алга ташиж байдаг хүн болгоно” гэж ярьдаг байжээ. Үнэхээр Буддарь хүү нь аавынхаа мөрөөдлийг биелүүлсэн юм. Хожим нэрт эрдэмтэн түүхч Ш.Нацагдорж гуайгаас: “Та Буддарь багшийн талаар ярьж өгөөч” гэж асуун сонирхоход минь: “Мартын 8-ны баяраар манай сургуульд ирээд “Мартын 8 мандтугай” гэж орос, англи, герман, франц, япон таван хэлээр хэлж билээ” гэж хэлсэнсэн. Үүнээс үзэхэд Буддарь гэгч нь ганц үг дуугараад алга ташуулдаг хүн болсон нь харагдана бус уу?” гэж ахмад орчуулагч, сэтгүүлч Г.Амар гуай нэгэнтээ дурсан бичжээ (Амар, 2003:13).

1920-иод оны үед Монголд хайгуул судалгаа хийсэн томоохон экспедицийн тоонд Р.Ч.Эндрюс (1884-1960)-ийн удирдсан Америкийн Байгалийн түүхийн музей, Америкийн Азийн нийгэмлэгийн “Ази” сэтгүүлтэй хамтран явуулсан Төв Азийн судалгааны гуравдугаар анги (1922, 1923, 1925) зүй ёсоор орно. Монгол улсын говь нутагт* явагдсан энэ судалгааны ангийн бүрэлдэхүүнд: экспедицийн удирдагч, амьтан судлаач Рой Чэпман Эндрюс, палеонтологч Вальтер Гренжер, геологич Чарльз Берки, геологич Фредерик Моррис, археологич Н.Нельсон, палеоботаникч Ральф Чаней, эмч Гарольд Лукс, амьтан судлаач Клиффорд Поппе, газрын зурагзүйч, фото зурагчин Л.Робертс, Ф.Бутлер, Г.Робенсон зэрэг хүмүүс оролцжээ (Зураг 2-3).

Уг экспедиц Монгол Улсын Гадаад Явдлын яамаар дамжуулан, Засгийн газраас зохих зөвшөөрөл авч, Судар Бичгийн Хүрээлэнгийн дарга О.Жамъян (1864-1930), эрдэмтэн нарийн бичгийн дарга Ж.Цэвээн (1881-1940) нартай, өөрөөр хэлбэл,

* БНМАУ-ын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн материалаар 1940 оны 12 дугаар сард эмхэтгэн зохиосон бөгөөд эдүгээ Монгол Улсын ШУА-ийн архивийн СХ. 1, Д-1, ХН. 36-д хадгалагдаж байгаа “Монголыг судлах зорилгоор 1923 оноос 1940 он хүртэл ажилласан эрдэм шинжилгээний ангиудын жагсаалт” хэмээх баримтад: “Р.Ч. Эндрюс даргатай Америкийн эд өлгийн түүхийн музейн шинжилгээний анги. Чиглэл нь: 1. Хаалган – Улаанбаатар - Мишиг гүн - Сайн ноён - Бага Богд (Говь-Алтай) – Бүрэнсайхан –Баянзаг - Сайр ус – Хаалган. 2. Хаалган - Баянзаг (Гурвансайханаас хойшхи) – Цагаан нуур (Бага Богд) – Хаалган. 3. Хаалган – Баянзаг - Орог нуур – Алтайн нурууны ар (Улиастайн уртраг хүртэл ба Их Богд уулнаас урагш) – Баянзаг – Хаалга даваа – Хөх хотын зам – Бор Оцон. Ажлын үр дүн: Геологи, палеонтологи, амьтан судлалын чиглэлээр ихэвчлэн ажиллаж байр зүйн (топографийн) зураглал хийсэн. Кино зураг авсан. Бүтээлүүд хэвлэгдсэн” хэмээн тэмдэглэжээ (Монгол-Зөвлөлтийн соёл, шинжлэх ухаан, техникийн харилцаа 2000: 323-324).

Монголын шинжлэх ухааны байгууллагатай гэрээ байгуулан, тодорхой нөхцөлтэйгөөр ажиллаж байсан ажээ.

Судар бичгийн хүрээлэн, Америкийн талтай 1925 оны 5 сарын 29-нд байгуулсан гэрээний гол утга нь: Америкийн тал Монголын говь нутагт эрт галавын амьтан, ургамлын судалгаа хийхдээ, Монгол улсын хууль, эрхзүйн актын дагуу явуулах ба ямар нэг арилжаа наймааны зүйл хийхгүй, эрдэс баялаг эрэхгүй, зөвхөн газрын дээр болон доор дарагдсан амьтан ургамлыг судлах бөгөөд бүрэн бүтэн хэвээр олдсон палеонтологийн олдвор яс, мөн бусад ховор олдвор, археологийн онцгой зүйлийг Судар бичгийн хүрээлэнд үлдээх ба аяллын замын зураг, шинжилгээний тайлан, фото зураг зэргийг хүрээлэнд өгч байхаар тохирчээ. Мөн зарим олдворыг Америкийн Нью-Йорк хот дахь Байгалийн түүхийн музейн лабораторид боловсруулсны дараа Судар бичгийн хүрээлэнд ирүүлэх бөгөөд тэдгээрийг хилээр гаргах, оруулахад гаалийн хураамж авахгүй байхаар тохирсон байна (Сэрээтэр, Цэрэв, Чадраа, 2002: 40).



Зураг 2. Америкийн Нэгдсэн Улсын Байгалийн Түүхийн Музейн Төв Азийн гуравдугаар экспедицийн баг бүрэлдэхүүн 1922 онд Цагаан нуур хэмээх газар. Дунд эгнээнд, зүүн гар талаас: Morris, Colgate, Granger, Badmajapoff, Andrews, Berkey, Larsen, Shackelford, эхний ба арын эгнээнд экспедицийн монгол, хятад туслах ажилчид

Энэхүү гэрээг зохиож найруулах, англиас орос, монгол хэлээр орчуулах ажлыг Буддарь хийж гүйцэтгэснээс гадна тэрээр уг экспедицийн ажилд Монгол улсаа төлөөлөн биеэр оролцож гэрээнд заасан үүрэг болзлыг биелүүлэх шаардлагыг зүй ёсоор тууштай тавьж байв. Экспедицийн нэг ажилтнаас 1925 оны 6 сарын 26-нд Ж.Цэвээнд оросоор бичсэн нэгэн захидалд “...Буддарь Дэмчиков, Эндрюс нар олборлосон ясандаа цэвэрлэгээ хийхээр Улаанбаатар явсан ...” гэх мэтээр өгүүлсэн

нь Буддарь Эндрюсийн экспедицийн нарийн чимхлүүр ажилд хүртэл биечлэн оролцсоныг харуулж байна (Чойжамц, 1996).

Тийнхүү хамтарсны ачаар хайгуул шинжилгээний ажил хоёр талдаа үр ашигтай болж уг экспедици тэр үеийн ханшаар 31925 долларын үнэ бүхий зүйлийг Монгол улсад өгчээ (Lomborinchen, 1997: 21).

Эл шинжилгээний ангид бидний олж мэдсэнээр 1920-иод оны Монголын шилдэг сэхээтний нэг, тухайн үед манай оронд ирж ажилласан олон улсын бараг бүх экспедицийн зохион байгуулалтын ажилд чухал үүрэгтэй оролцож байсан Цогт Гармаевич Бадамжапов (1879-1937) зөвлөхөөр (Чимитдоржиев, Раднаев, Бадмажапов, 2006: 5-16) ажилласан (Зураг 2) ба хээрийн шинжилгээний ажилд Дэмчигийн Буддариас гадна Бадамжаповын дүү Далай, тэмээн жингийн ахлагч Мэйрин Цэрин, Цэвэгжав нарын зэрэг нилээд хэдэн монгол хүн оролцсон ажээ. Энэ тухай хожим Америкийн эрдэмтэн Рой Чэпмэн Эндрюс 1932 онд Нью-Йорк хотноо нийтлүүлсэн “Төв Азийг шинээр байлдан дагуулсан нь” хэмээх бүтээлдээ зарим зүйлийг бичсэн байх бөгөөд Буддариин нэрийг эцгийн нь овгоор Жон Димчиофф (John Dimschikoff) хэмээн тэмдэглэсэн байдаг*.



Зураг 3. Төв Азийн гуравдугаар экспедицийн америк судлаачид 1923 онд монгол, хятад ажилчдын хамт авахуулсан гэрэл зураг. Дунд эгнээнд, зүүн гар талаас Granger, Osborn, Andrews, Morris, Kaisen. Арын эгнээнд зогсож буй, зүүнээс хоёр дахь: Vance Johnson, Albert Johnson, Young, Olsen.

* Ахмад орчуулагч Амар гуайн зөв зүйтэй тэмдэглэсэн ёсоор, тэр үеийн буриад сэхээтнүүд эцгийнхээ нэрийг орос маягаар овог болгон –ов, -ев төгсгөл залган, албанд өртөхөөрөө монгол заншлаа баримтлан –ийн, -уун, -үүн дагавар залгаж бичдэг байсны нэг нь энэ бөгөөд Бараагийн, Жамбалон, Дондубон гэх зэргээр бичдэг, бичсээр ч байгаа билээ [Г. Амар 2003: 18].

Р.Ч.Эндрюс энэхүү номондоо: “Өргөөд хийсэн хэлэлцээрүүдээ дүгнэж дуусах үед үдийн хойно 5 цаг болж байв. Бид харуй бүрий болохоос өмнө хэд хэдэн саад бартааг давж задгай талд хүрэх хэрэгтэй байлаа. Өргөөгөөс хөдлөөд ачааны машинд сууж яваа Цэрингийн хамт хоёр буриад бидэнтэй нэгдлээ. Нэг нь Далай Бадамжапофф бөгөөд тэрбээр ноён Ц.Бадамжапоффын хүсэлтээр манай экспедицид нэгдсэн зочин юм. Тэр англиар их сайн ярьдаг, бас тун аятайхан сайн залуу байсан. Бид түүнийг хүлээн авч байгаадаа их баяртай байсан. Нөгөө нэг хүн нь Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн төлөөлөгч Жон Димчиофф. Тэр аль нэг сургуулийн “профессор” байсан. Түүний “заадаг” хичээлд нь хэн бүхний мэдэх шинжлэх ухааны салбар багтдаг гэсэн. Тэр дөнгөж хорин дөрвөн* настай, одоо ч өөрт нь сурах зүйл их байгаа ч үүнийгээ нэг их тоодоггүй юм шиг байсан.

Димчиофф бас бидний өдөр тутмын ярианаас яагаад Монгол ирснийг тодруулах үүрэгтэй Нууц албаны итгэмжлэгдсэн тагнуулын нэг байсан юм. Нэгэнт тэрбээр англиар тааруухан ярьдаг байсан болохоор бидний ярьсны талыг нь л дөнгөж ойлгож байв. Хэрэв бидэнтэй холбоотой ямар нэг гайхалтай зүйл “нээж” олбол, тэр талаараа сайхан илтгэл бичиж их зүйлд хүрнэ гэдэгтээ тэрбээр итгэлтэй байлаа. Үүний нэг жишээ нь экспедицийн гишүүн болж зүсээ хувилгасан Бээжин дэх Н.В.М. дипломат төлөөлөгчийн газрын нэгдүгээр нарийн бичгийн дарга ноён Гордон Верекер байв. Ноён Верекер өмнөх намар нь нэг удаа зүгээр аяллын зорилгоор намайг дагалдан Өргөөд ирж байсан удаатай. Бидний ярианаас ойлгосныхоо дагуу Димчиофф бичсэн илтгэлдээ Америк, Англи нь Монголыг өөрсөндөө нэгтгэх зорилго агуулж байна хэмээн дурдсан. Өөр тиймэрхүү утгатай юм ч зөндөө байсан. Өргөө дэх Нууц алба нь Димчиоффын илтгэлүүдэд итгэхэд дэндүү бэлэн байсан боловч Бадамжапофф тэднийг хүлээзнэж байхыг ятгасан юм. Далай, Жон нарыг буцаж ирэх үед сүүлд бичсэн бүх юм нь хэрэгсэхгүй болгогдсон. Гэхдээ азтай тохиолдлоор ч юмуу биднийг Гадаад Монголын хилийг давсан бол баривчлан Өргөөд хүргэх гэсэн санаархал нь биелээгүй билээ.

Сүүлд нь Нууц албанаас бас нэг хүн биднийг Цагаан нуурт байхад нэгдсэн юм. Тэр их төлөв түвшин залуу байсан. Түүний илтгэл нь Далайгийн баталснаар бол золгүй Димчиоффт нилээд үл итгэсэн байдалтай байжээ. Эцэст нь сүүлийн хүн (Буддарийг хэлж буй бололтой У.Э., Д.Э.) экспедицийн талаар бичиж өгсөн илтгэлээсээ болж Өргөөгөөс Сибирь дэх гэр лүүгээ буцсан юм. Тэр хангалттай нөлөө бүхий хүн байсан тул хоёрхон жилийн дараа Өргөөд буцаж очих зөвшөөрлийг олж, Далайн хамт Герман явжээ. Тэр зардлын мөнгөнөөсөө хулгайлж, Далайд хор өгсөн. Тэгээд мөнгө хулгайлж байхыг нь илчлэн нэхэмжилсэн тул Далай амиа хорлосон гэсэн илтгэл бичиж өгсөн. Димчиоффтой ажилласан үе бол тиймэрхүү хүмүүсийг ажлын талбарт авч явахаар экспедицийг хүчлэх нь ямаршуу үр дүнд хүргэдгийг харуулсан тод жишээ болсон юм. Ер нь бол тийм хүмүүс шинжилгээний ангийг чин сэтгэлээсээ сонирхсон биш, харин эсрэгээр гай тарих замаар өөрсдийгөө таниулахыг бодсон хүмүүс байдаг. Хэрвээ удирдагч нь хэнийг

* Тухайн үед Буддарь багш үнэн хэрэгтээ хорин дөрөвтэй биш, харин гучин хоёр (31) настай байжээ.

хамт дагуулж явахгаа сонгох эрхтэй байсансан бол энэ нь огт өөр асуудал байх байлаа” (Andrews 1932: 263-264) хэмээн нилээд учир битүүлэг, хар бараан талаас нь бичжээ.

Энэхүү үйл явдлын тухай хожим Америкийн Байгалийн Түүхийн Музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа Эндрюсийн экспедицийн материалыг ашиглаж 2001 онд “Луугийн анчин” хэмээх ном хэвлүүлсэн Америкийн зохиолч, археологич Чарльз Галленкамп арай дэлгэрэнгүй, тайлбарласан байдаг. Галленкампын бичсэнийг уншихад тухайн үед Буддарь багш олон газар явж юм үзэж нүд тайлсан хэл устай хүний хувьд экспедицийн үйл ажиллагаанд маш идэвхтэй оролцож, нэн ялангуяа гадаадын эрдэмтэн судлаачид монгол хүмүүстэй харилцан эрх тэгш хамтран ажиллах тал дээр Монголын Судар бичгийн хүрээлэнгээс албан ёсоор томилогдсон эрдэм шинжилгээний ажилтны хувиар өндөр шаардлага тавьж ажиллаж байсан нь харагддаг. Гэвч тухайн үед Монгол оронд өрнөсөн улс төрийн үйл явдал ба олон улсын харилцааны хурцадмал байдлаас болж түүний талаар гадаадын эрдэмтдийн дунд одоо болтол буруу ташаа дүгнэлт байсаар байгааг дурдахгүй өнгөрч боломгүй санагдана. Тухайлбал, америк судлаачийн бичсэн уг номонд Буддарь багшийн тухай дурсахдаа дан ганц сөрөг талаас нь, тэдний экспедицийн үйл ажиллагааг Засгийн газрынхаа даалгавраар тагнаж байсан, хор найруулагч тагнуул туршуул гэх мэтээр аль өөдгүй муухай үг болгоныг хэрэглэн бичсэн байх юм. Буддарь гуайн талаар “Луугийн анчин” номонд америк зохиолчийн бичсэн хэсгийг дор монголчлон сийрүүлбэл:

“... Нөгөө нь Жон Димчиофф гэж бусдад хор хүргэхээр, хэтрүүлсэн худал мэдээлэл илтгэлийг дарга нартаа аль хэзээний бэлдчихсэн явж байдаг, тийм өөдгүй муухай хүн байсан. Тэр хэдийгээр хорин дөрөвхөн настай боловч, өөрийгөө хэн бүхний мэдэх “шинжлэх ухааны салбарыг” заадаг, Өргөөгийн аль нэг сургуулийн профессор гэж өргөмжилсөн нэгэн байв. Хожим Цагаан нуурт шинжилгээний анги нууц ажиллагааны гуравдагч гишүүнтэй санамсаргүйгээр тааралдахад тэрбээр Далайн нэгэн адил шулуун шудрага, илэн далангүй болж өөрчлөгдсөн байсан (Gallenkamp 2001: 200).

”... Эндрюс Гадаад Монголын гадна байсан өөрийн хүмүүс ба багаж төхөөрөмж рүүгээ хүрэхийн тулд энэ орноос шуурган гал дэгдэхийн өмнө буюу жинхэнэ зөв үедээ явсан юм. Энэ үйл явдал үнэн хэрэгтээ түүний шинжилгээний ангид хамт явж байсан, Засгийн газрын төлөөлөгч, хэт их чармайлт оролдлоготой коммунист Жон Димчиоффын хүргэсэн мэдээллээр 8 сарын 15-нд Улаанбаатар хотын сонин мэдээнд нийтлэгдсэн өгүүллийн үр дүн болж эхэлсэн билээ.

Чухамдаа Эндрюс 8 сарын 20-нд Бээжинд хийсэн дөрөв хоногийн албан аяллаасаа буцаж ирэх хүртлээ үүсээд буй нөхцөл байдлын тухай юу ч мэдээгүй байлаа. Сонин мэдээгээр Монголын нутаг дэвсгэрээс түүний экспедици хөөн зайлуулагдсан гэж хот даяар тархаасан цуурхал Эндрюсийг тэвдүүлжээ. Түүнийг Засгийн газартай байгуулсан тохиролцоогоо зөрчсөн, большевизмийн эсрэг суртал ухуулга тараасан, газрын тос ба эрдэс баялаг хайсан, тус орныг эзэрхийлэхийг санаархсан гадаадын харгис хүчинтэй сүлбэлдсэн бөгөөд шинжилгээний ангийн

бүрэлдэхүүнд зарим тооны сэжигтэй хүмүүсийг цэрэг дайны утгаар агуулан авч явж байсан хэмээн буруутгажээ.

Димчикофф өөрийн дарга нарын хардалт сэрдэлтийг дэвэргэж Эндрюсийг шийтгэх хангалттай хор найруулсан байв. Улаанбаатар хотын мэдээнд тус экспедицийн ажлын талбартаа ямаршуу булай зүйл хийсэн болохыг жижиг сажиг зүйл дээр хүртэл буруутган бичсэн нийтлэлдээ Димчикофф, тус экспедици зөвшөөрөгдөөгүй нутаг дэвсгэрт ажиллаж хэмжилт газрын зураг үйлдсэн, “Агуу их Эндрюс” нь зөвхөн өөртөө ан хийхийг зөвшөөрч, бусдад хориглосон, монголын ажиглагчдыг ихэмсэгээр үл ойшоосон, тэднийг “доод арьстан” гэж нэрлэсэн, майхандаа орох гарахыг нь хүртэл хязгаарлаж, шивнэхээс өөрөөр яриулдаггүй байсан хэмээн гүжирджээ. Уг мэдээнд цааш бичихдээ, 7 сарын 4-нд шинжилгээний ангийнхан хэтэрхий их виски ууж согтуурхан нуурын ус руу бие биенээ унтлагын хувцастай нь авч чулуудсан бөгөөд зарим нь гутал, цаг зэргээ усанд унагаж алдсан боловч ус руу орж юмаа олж авах тэнхэлгүй болтлоо хөлчүүрсэн байсан гэх зэргээр шүүмжилжээ. Иймэрхүү учир утгагүй, хөнгөмсөг явдлын түүх нь Улаанбаатарын сонин тэргүүн нүүрэндээ “ЭНДРЮСИЙН ЭКСПЕДИЦИ МОНГОЛЫГ ОРХИХ ЁСТОЙ” гэсэн ууртай гарчиг тавихад хүргэсэнд гайхах явдалгүй байв.

Далай Бадамжапофф болон Цагаан нуурын дэргэд шинжилгээний ангитай нийлсэн Монголын засгийн газрын гурав дахь төлөөлөгч нар Улаанбаатарт эргэн ирж Димчикоффийн мэдэгдлийг онцгойлон няцааснаар байдал улам ээдрээтэй болжээ. Гэвч Эндрюс болон түүний экспедицийн нэгдмэл байдлыг тууштай өмгөөлж байсан Бадамжапоффийн хамгаалалт учир битүүлэг явдал болсон бөгөөд хэзээ ч тайлбарлагдаагүй юм. Эндрюс хожим нь мөнөөх булай Димчикоффийг шинжлэх ухаанчдыг төлөөлж чадаагүй гэсэн үйлдэлдээ буруутгагдан өөрийн төрөлх нутаг Сибиртээ цөлөгдсөн хэмээн баттай эх сурвалжаас сонсжээ. Хоёр жилийн дараа тэрбээр Улаанбаатарт буцаж ирээд дахиад Далай Бадамжапоффийнхаа хамт Герман оронд албан томилолтоор явсан байна. Тэгээд Димчикофф тэдний зардлын мөнгөнөөсөө хулгайлж, Далайг хордуулсан. Гэхдээ Димчикофф мэдүүлэг өгөхдөө, Далайг мөнгө хулгайлсныг нь илрүүлэн мэдсэнд, тэр амиа хорлосон гэж өчиглөсөн сурагтай байдаг” (Gallenkamp 2001: 205-206) гэх зэргээр бичсэн ажээ.

Р.Ч.Эндрюсийн удирдсан Төв Азийг судлах гуравдугаар экспедицийн Монголд явуулсан үйл ажиллагаатай холбоотой архивын зарим баримтад тулгуурлан манай ахмад судлаач Р.Ломборинчен энэ шинжилгээний анги чухам ямар учраас Монголоос гарсан тухай үнэн учрыг олж тодруулахыг оролдсон байдаг. Түүний сурвалжлан нийтлүүлсэн баримтаас үзэхэд, тухайлбал Р.Ч.Эндрюс 1925 оны 9 сарын 28-ны өдөр Бээжин хотоос Монголын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Ж.Цэвээнд илгээсэн захидалдаа тухайн үед түүний экспедицийн талаар гарсан цуурхлын учрыг олохыг эрмэлзэж байжээ. Сонины мэдээнд гарсан санаанд оромгүй зүйлүүд нь тэдний шинжилгээний ангитай 1925 оны зун хамт явж байсан орос хэлээр чөлөөтэй ярьдаг Димчиков гэгч холбоотой гэж Эндрюс сэжиглэсэн байна.

Буддарь Димчиков Монголын Шинжлэх ухааны байгууллагаас албан ёсоор томилогдсон төлөөлөгч байснаас гадна англи хэлний төгс мэдлэгтэй байсан (үнэн хэрэгтээ) тул Эндрюс тэр залууг шинжилгээний ангидаа нэмж авсан юм. Гэвч Эндрюс анхнаасаа түүнийг мэдээлэгч гэж сэжиглэж байсан болохоор тэр хоёрын харилцаа төдийлөн сайн байсангүй. Цаашилбал Димчиков ч Эндрюс өөрийг нь ашиглаж байна гэж бодон “Эндрюс миний шинжлэх ухааны мэдлэгийг ашиглах гэж биш харин Монголд ажиллах зөвшөөрөл авахдаа туслуулахаар авчиржээ” гэж дургүйцлээ илэрхийлсэн захидлыг 1925 оны 6 сарын 26-ны өдөр Ж.Цэвээнд илгээж байжээ. Димчиковыг тэдний ажлыг санаатайгаар тасалдуулахыг оролдож байгаа гэж буруутгаж байсан Эндрюс түүний шинжилгээний багт ажиллаж байсан өөр нэг монгол хүн болох Цэвэгжав гэгчтэй түүний талаар ярьсан яриа байдлыг улам хүндрүүлсэн аж. Димчиков бичихдээ “Америкууд нутгийнхантай Австралийн зэрлэгүүд юмуу эсвэл Хойд Дакоттагийн Пуэбло омгийн гишүүн юм шиг авирлаж харьцаж байсан” хэмээн шүүмжилж байв.

Ер нь бол Димчиков Америкуудын талаар зүгээр нэг гомдоллож байсангүй. Тэр шинжилгээний явцад нарийн ажиглалт хийж байсан тухайгаа “Бид Баянзаг гэдэг газраас динозаврын гавал ясыг улаан өнгөтэй давхаргаас олсон. Тиймэрхүү динозаврын яс бүхий элсэн чулуун давхарга нь ил задгай болохоор их амархан олдож байсан. Жишээ нь миний бие гэхэд *Baluchitherium*-ийн гуя ташааны яс бүтнээрээ үлдсэнийг олсон” гэх зэргээр бичжээ. Тэрээр цааш нь “Америкууд манхан сэвхүүлүүдийг өнгөц харсан болохоор тэдэнд олдоогүй зүйл Монголын судлаач нарт үлдэх болно” гэж онцлон тэмдэглэсэн байна. Шинжилгээний үеэр Димчиков амьтны болон археологийн олдвор бүхий 3 хайрцаг цуглуулга хийсэн байна. Түүний цуглуулгыг Төв Музейд буюу одоогийн Байгалийн Музей олон жилийн турш дэлгэн тавьсан боловч одоо үзэх боломжгүй байгаа юм.

Димчиков байнга Эндрюсын орчуулагчаар ажиллаж байсан тул шинжилгээний ангийн бусад хүмүүстэй нэг их холбоотой байсангүй. Гэхдээ 2 геологич нь заримдаа шинжилгээний байрлаж байгаа газраас 15-20 км холдоод байгааг тэрээр анзаарчээ. Нэг нь Америкийн алдартай геологичдийн нэг, газрын тосны хайгуулч доктор Берки байсан бөгөөд тэрбээр Димчиковын тэмдэглэснээр ойр ойрхон Стандарт Ойл Компаниас их хэмжээний мөнгө хүлээн авдаг байжээ. Түүнээс гадна Америкийн судлаачид гэрээнд зааснаас өөр газар нутагт ажилласан ба шинжилгээний ангийн явсан газруудын газрын зураг нь байх ёстойгоосоо илүү нарийвчилсан байхыг анзаарчээ. Тухайлбал, байрзүйн зурагчид нь өндөр нарийвчлалтай багаж төхөөрөмж хэрэглэж уул толгод, өндөрлөг газрууд, нуур, хатсан голын сав газар, горхи, худаг, бут сөөг, зам бүрийн зургийг гаргаж шинжилгээний ангийн отгийн эргэн тойрон 10 милийн радиус дотор далайн түвшинээс дээш 20 футын нарийвчлалтай хэмжилт хийж явсан байна.

Р.Ч.Эндрюс Монголоос гарсан хойно 1926 оны 5 сарын 8-ны өдөр Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Цэвээнд илгээсэн захидалдаа: “Бид Монголд байх 5 жилийн хугацаандаа хууль журмыг огт зөрчөөгүй билээ. Энэ бүхний ард Димчиков байгаа. Эдгээр цуурхлыг Димчиков тараасан гэж

надад хэлсэн. Юу болоод байна вэ? Бид одоо найз нөхөд хэвээрээ юу эсвэл үгүй юу?” хэмээн асуусан байдаг. Цэвээн хариу захидалдаа, Монголын Засгийн газар дээрх цуурхлуудад холбогдолгүй гэдгийг батлан “Бага зэргийн буруу ойлгосон нь ийм байдалд хүргэсэн. Энэ нь бидний ажлыг нураалаа” гэж бичиж байжээ (Lomborinchen 1997: 9-13).

Үүнээс үзэхэд тухайн үед Америкийн шинжилгээний анги цаашид Монголд тогтвортой ажиллахад ихээхэн хүндрэл бэрхшээлтэй тулгарч байсан нь илэрхий боловч энэ нь харин Р.Ч.Эндрюсийн бодож байсан ба Ч.Галленкамбийн өнгөц дүгнэн бичсэн шиг дан ганц Монголын талаас буюу Буддарь мэтийн ганц нэг хүнээс шалтгаалсан хэрэг огт биш бөгөөд хэргийн цаад жинхэнэ учир шалтгаан нь Америкийн тал Зөвлөлт Холбоот Оросын тухайн бүс нутагт дангаар ноёрхох ашиг сонирхлыг хөндсөнтэй холбоотой бололтой. Үүнийг ч тухайн үеийн хөндлөнгийн зарим баримт сэлт гэрчлэн харуулж байна.

1925 оны 1 сарын 31-нд Оросын ШУА-ийн Геологийн музейн Төв Азийн хэлтсийн эрхлэгч И.П.Рачковскийн бичсэн илтгэх хуудаснаа: “Америкийн геологичид зүүн өмнөд ба зүүн Монголыг геологийн талаар шинжлэх ажлыг 1922 онд эхэлсэн бөгөөд дорноос Хангайн нурууны чиглэлээр баруун тийш аажмаар ахиж байна. Тэдний гол зорилго нь асар их үнэ цэнэтэй материалыг (сээр нуруут амьтдын үлдэгдэл) эзэмших явдал юм. Тэд судлаж буй бүс нутгаас уг материалыг их хэмжээгээр ачуулсан бөгөөд баруун тийш (1923 онд Оросын ШУА-ийн Монголын шинжилгээний ангийн мэдээгээр эндээс бас сонирхолтой олдвор олдож болно) ахих үед цаашид хийсэн цуглуулга дэлхийн ач холбогдолтой эрдэм шинжилгээний баримт материал олсны хувьд америкчууд ашигтай байр суурьтай болно. Одоо үед энэхүү шинжилгээний ангийн олсон үр дүн нь Төв Азийн энэ хэсгийн геологийн бүтцийн үндсийг магадлах утгаар америкийн геологичид бага зүйл хийсэн ба тэд тун тааламжгүй нөхцөлтэй тулгарсан ба өөрийн зураглалаа зохиоход хүрсэн хэсэг бусын мэдээний зарим тохиолдолд баруун Монголын нутгийн нилээд тааламжтай нөхцөлд ажиглагдсан геологийн жинхэнэ харилцаанд нийцэхгүй байгааг олж харах боломж олгож байгаа юм. Америкийн геологичид цаашид баруун тийш ахих тусам Азийн эх газрын төв хэсгийн геологийн үндсэн хэсэгт хамаарах асуудлаар үгээ хэлэх боломж олгох нутгийг хамрах болно. Хэд хэдэн тогтмол шинжилгээ явуулсны дараа хэвлэгдсэн Оросын ШУА-ийн бүтээлүүд Төв Азийн геологийн асуудлыг магадлахад тэргүүлэх байр сууриа Америкийн эрдэмтдийн бүтээлүүдэд тавьж өгөх, улмаар төв ба баруун Монголын хүдрийн орд газруудын утгаар ч нилээд сонирхолтой бүс нутагтай холбоо бүхий шинжилгээнээс татгалзахад хүрэх болно. Тус орныг геологийн үүднээс судлах нь ашигт малтмалын баялгийг нь танин мэдэх ач холбогдолтой. Геологийн ажлуудын зохион байгуулалт удирдлагыг Америкийн эрдэмтдийн гарт шилжүүлэх нь Монголын шинэ Бүгд Найрамдах Улсын болон ЗСБНХОУ-ын эрх ашигт нийцэхгүй” (Монгол-Зөвлөлтийн соёл, шинжлэх ухаан, техникийн харилцаа 2000: 42-43) хэмээн цохон тэмдэглэсэн байдаг.

Эндрюсийн экспедицийн талаар тухайн үед гарсан шуугианы гол эзэн нь судлаач Р.Ломборинченгийн бичсэнээр, Буддарь Димчиков биш харин Зөвлөлт Оросын сургагч нарын шууд заавраар ажиллаж байсан Цэвэгжав гэдэг хүнтэй холбоотой бололтой. Энэ нь 1922 онд Зөвлөлтийн Аюулаас хамгаалах байгууллагын загвараар үндэслэн байгуулагдсан Дотоод яамны нууц сүлжээ бөгөөд байгуулагдсан үеийн нь эхний жилүүдэд Зөвлөлтийн хувьсгалчид удирдаж байсан ба хожим ч гэсэн Зөвлөлтийн зааварлагч, зөвлөгч нар үйл ажиллагаанд нь чухал үүрэг гүйцэтгэж байв. Цэвэгжавын талаар мэдээлэл одоо хир нь олддоггүй бөгөөд үнэндээ Цэвэгжав гэж чухам хэн байсан нь ч тодорхойгүй юм. Ломборинчен цааш бичихдээ “Сонины өгүүллүүдийг үзвэл Америкийн экспедици дараахь шалтгаанаар хөөгдөх болсон гэжээ:

1. Хаалганд хүрэх үед шинжилгээний ангийнхан бүрэн зэвсэглэсэн байсан ба тэдний Монгол дахь үйл ажиллагаанд саад болсон хэн бүхэнд хүч хэрэглэнэ хэмээн айлган сүрдүүлсэн.
2. Шинжилгээний анги Монголын Засгийн газраас хориглосон бүсэд ажилласан.
3. Шинжилгээний анги нь шинжлэх ухааны ажилд саад болсон хэн боловч амь насаараа төлөх болно гэдгийг зарлаж байсан.
4. Шинжилгээний анги судалгааны хэсгийн бүрэлдэхүүндээ Британийн Консулын газрын нарийн бичгийн дарга болон Монголын Засгийн газраас зөвшөөрөгдөж бүртгүүлээгүй өөр үл мэдэгдэх 2 хүнийг багтааж явсан.
5. Шинжилгээний анги нь цэргийн зориулалттай газрын зураг авч явсан.

Шинжилгээний ангийнхан бүрэн зэвсэглэсэн байсан гэдгийг Эндрюс 1928 оны 9 сарын 28-нд Бээжингээс илгээсэн захидалдаа тайлбарлахдаа тэд авч явсан винтов, гар буу бүртээ Монголын Засгийн газрын зөвшөөрлийг авсан байсан гэжээ. Тэдгээр нь “спортын” зориулалттай байж. Зөвшөөрөгдөөгүй бүсэд зогссон тухайд гэвэл зөвхөн ганцхан газар буюу Сайн Ноён хан аймгийн “Хөгшин” ууланд малтлага хийхийг хориглосон байна. Эндрюс тэр уул руу явсан гэдгийг эрс няцаажээ. Гурав дахь шалтгааны талаар тайлбар өгөхөөс Эндрюс татгалзжээ. Шинжилгээний ангитай өөр ямар нэг хүмүүс хамт явсан гэж буруутгасныг Эндрюс мөн эрс няцаажээ. “Экспедицийн бүх гишүүд Монгол Улсын Засгийн газарт бүртгэгдсэн байсан бөгөөд бүгд өөрсдийн монгол паспорттой байсан” гэж. Түүнчлэн өөр улсын дипломат ажилтан тэдэнтэй нэгдсэн гэдгийг ч зөвшөөрөөгүй байна. Буруутгагдсан сүүлчийн шалтгаан бол тэд цэргийн зориулалттай газрын зураг авч явсан. Ер нь бол экспедици 2 төрлийн газрын зураг авч явсан бөгөөд замын газрын зургууд болон ашигт малтмал олдсон жижиг бүсүүдийн газрын зургууд болно. “Эдгээр газрын зургуудыг цэргийн ач холбогдолтой гэж үзэх ямар ч боломжгүй юм” гэдгийг Эндрюс тэмдэглэж байв. Дэлхийн хэвлэлээр мэдээллээр түгсэн ч гэсэн Монголын Засгийн газраас тэднийг хөөсөн гэдэгт Эндрюс итгэх эсэхдээ эргэлзсээр байв. Монголын төв хэвлэл болох “Үнэн” сонинд үнэн хэрэгтээ тэднийг хөөн зайлуулах талаар юу ч хэвлэгдээгүй. 1926 оны 1 сарын 28-нд

Америкийн Түүхийн Музей, Нью-Йорк, Эндрюст явуулсан телеграммдаа Ж.Цэвээн “Манай Засгийн газар хөөсөн зүйл байхгүй бөгөөд шинжилгээний ангийг Монгол улсаас гаргана гэж бодсон удаа ер үгүй” хэмээн тайлбарлаж байжээ. Гэвч ингэж хачирхалтай байдлаар гарч явсан нь нууц хэвээр үлдэж, хариулт нь говийн элсэнд ууссан мэт шингэсээр байх бизээ” (Lomborinchen 1997: 13-14) хэмээн хэргийн учрыг тайлсан байна.

Тухайн үед Улаанбаатарт сууж байсан Зөвлөлт Коминтерний төлөөлөгчийн дарамт шахалт улам бүр нэмэгдэн байсан хэдий ч 1924 оны 11 дүгээр сард Монголд байгуулагдсан шинэхэн Бүгд Найрамдах Улсын удирдлагын баримталж байсан үндэсний-ардчилсан чиг бодлогын ачаар Монголын шинэ үеийн охид хөвгүүдийг гадаад орны дунд сургууль, гимнази, их дээд сургуулиудад сургаж боловсрол эзэмшүүлэх анхны алхам тавигджээ. 1925 оноос өмнө Монголын залуучууд гадаадад боловсрол эзэмшинэ гэдэг бол үнэхээр онцгой явдал байлаа. Бүр өөртөө эзэрхэх автономит засагт “Гадаад Монгол” (1911-1919)-ын үеэс эхлэн монголчууд энэ чиглэлээр эхлээд Орос улстай холбоо тогтоосон байна. Чингэж 1914-1917/18 оны үед хэсэг монголчууд Эрхүү хотноо багшийн мэргэжлээр суралцсан ба 1923-24 онд монгол залуусын дараагийн ээлж эрдэм сурахаар Зөвлөлт Оросыг зорьжээ. Харин барууны капиталист ертөнцөд сурч боловсрол эзэмших боломж “бодит социализм”-ын систем нурж унах хүртэл буюу 1990 онд ардчилал эхлэх үе хүртэл зөвхөн цорын ганц удаа буюу 1925/26 оноос 1929/30 оны хооронд тохиосон юм. Бүгд Найрамдах Улс тунхагласан эхэн үеийн Монголын удирдагчдын хийсэн алхмуудыг өнөөдрийн өндөрлөгөөс харвал ер бусын гэж хэлж болно. Энэ нь олон улсад нээлттэй бөгөөд үндэсний ардчилсан чиг шугамыг баримталж байсан бие хүмүүс, тухайлбал 1923 оноос Ерөнхий сайдаар томилогдсон Балингийн Цэрэндорж (1868-1928), хувьсгалын хуучин партизан бөгөөд 1924-1928 онд МАХН-ын Төв Хорооны дарга болсон Цэрэн-Очирын Дамбадорж (1899-1934), тэрчлэн эдгээр жилүүдэд Ардын Гэгээрлийн яамны сайд байсан Эрдэнэбатхаан (1888-1947) нарын үйл ажиллагаатай салшгүй холбоотой байв. 1924 онд Дамбадорж Итали, Франц, Германд айлчлал хийж үүний үр дүнд 50 монгол залууг Герман, Францад эрдэм сургахаар тохирсон байна. Түүний баруунд хийсэн аялал ба айлчлалын үр дүн Зөвлөлтийн “зөвлөх”-ийн зүгээс бол ихээхэн итгэл эвдсэн хэрэг болсон бөгөөд энэ тухай тэр үеийн Коминтерний нөлөө бүхий төлөөлөгч М.И.Амгаев нэгэн илтгэлдээ: “Иймэрхүү залуу хүмүүс сэтгэлгээний хоёр салаа арга барилтай болж аваад эх орондоо очих ба энэ нь үндсэндээ харийн буюу дайсны соёлыг эзэмшсэн хүмүүс болж буцаж ирнэ гэсэн үг юм” хэмээн онцлон сануулж байжээ (Oehmichen 2006: 55).

1926 оны 5 дугаар сард БНМАУ-ын Засгийн газраас тусгаар тогтносон шинэ Монгол орны ирээдүйн хөгжил цэцэглэлтийн төлөө зүтгэх үндэсний өндөр боловсролтой мэргэжилтэн бэлтгэх зорилгоор 13-17 насны 35 хүүхдийн бүрэлдэхүүнтэй багийг Герман болон Франц улсад суралцуулахаар илгээсэн юм. Эл сурагчдыг хоёр хэсэгт хувааж, нэг хэсгийг нь ерөнхий боловсролын сургуульд, нөгөө хэсгийг нь Монголын Засгийн газрын цаашид хамтран ажиллах хүсэлтэй

үйлдвэрүүд дээр дадлага хийлгэж, нарийн мэргэжил эзэмшүүлэхээр зохион байгуулсан байв.

1926 оны 5 сарын 31-нд Стеттиний усан онгоцны зогсоолд Ленинградаас ирсэн нэгэн хөлөг онгоцоор 35 монгол хүүхэд, тэднийг халамжлан яваа гурван том хүний хамт хүрэлцэн иржээ. Тэд хөх даалимбан тэрлэгэн дээр цэнхэр дурдан бүс бүслэж, саарал эсгий малгай духдуулсан байх ба зарим нь өндөр түрийтэй орос ширэн гутал өмссөн байв. Тэднийг усан онгоцны буудал дээр Германы Засгийн газраас монгол хүүхдүүдэд туслуулахаар томилсон төлөөлөгч Сергей М.Вольф (1902-1979) хэмээгч угтан авч, улмаар тэд хотын гудамжаар төв вокзалыг чиглэн хоёр эгнээ жагсаалаар явжээ. Энэ тухай С. Вольфийн дуртгалд өгүүлэхдээ: “Тэдний ачаа нь ихэвчлэн хэрээс маягаар зөрүүлэн зангидсан торгон алчууранд баадагнасан том том дөрвөлжин боодолтой юмнууд байсан ба зарим нь Орост “япон сагс” гэж нэрлэдэг, цайвар шаргал өнгөтэй, сүрлээр сүлжиж хийсэн чемодан барьсан байв. Энэ бүхнийг нэг тэргэн дээр овоолж, хүүхдүүдийн хажуугаар гудамжаар чирэн явж байв. Стеттиний гудамжаар биднийг ийн явж байх нь хүмүүсийн анхаарлыг ихэд татаж байлаа. Маш олон хүмүүс надаас, энэ юун хүүхдүүд вэ, хаанаас ирсэн юм бол, хаашаа явж байгаа юм бэ, нүүдлийн цирк явж байна л гэж бодлоо гэх зэргээр асуулцан ярилцан байв... Биднийг төв буудалд ирэхэд хүмүүсийн тоо ч өдий төдийгөөр нэмэгдэж, улмаар цагдаа хүрч ирэхэд, би цаашдын таагүй зүйл болохоос зайлсхийж, энэ хүмүүс бол Германы Засгийн газрын зочид юмаа хэмээн тайлбарлав. Энэ нь ч ач тусаа үзүүлж, цагдаа нар хурсан олныг журамлан, биднийг хүлээлгийн танхимд оруулан өгөв. Тэгээд би ч хүүхдүүдэд гуравдугаар зэргийн галт тэргэнд суудал захиалж амжсан” (Wolf 1946: 76) хэмээн бичсэн байдаг.

Хүүхдүүдийг халамжлан яваа насанд хүрсэн гурван монгол эрийн хоёр нь европ маягаар хувцасласан байв. Тэдний ахмад нь болох нас тогтсон ноёнтон бол Монголын Ардын гэгээрлийн сайд Эрдэнэбатхаан байв. Тэрбээр Герман оронд хийж буй өөрийн айлчлалын далимд олон янзын гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурахаар төлөвлөсөн байжээ. Энэ хүн Баруун Европ руу охид, хөвгүүдээ илгээсэн Засгийн газрын гишүүний хувьд өөрийн биеэр хүүхдүүдийн хамт аялан ирсэн нь улс төрийн асар өндөр ач холбогдолтой байсан юм. Нэг залуу дагалдагчийг нь Дэмчигон (Буддарь У.Э., Д.Э.) гэх бөгөөд энэ хүн Ардын гэгээрлийн яамны Берлин дэх төлөөлөгчийн хувиар хүүхдүүдийн тухайд санаа тавьж халамжлах ба хүлээн авагч Германы талын боловсролын байгууллагуудтай хамтран мөнгө санхүү болон засаг захиргаа, зохион байгуулалтын талаар зохицуулж байх үүрэг хүлээсэн байв. Хүүхдүүдийнхээ нэгэн адил хөх даалимбан дээл өмссөн гурав дахь хүний нэрийг Далай гэх бөгөөд тэрбээр Дэмчигоны ажилд туслах даалгавартай байжээ (Goetting 2004: 18).

Берлин хотод тэднийг Монголоос ирсэн худалдааны төлөөлөгчдийн хэсэг болох Цэрэндорж Дашсампилон, Шилон К.Хурлаат нар хүлээж байлаа. Тэд Фроонауд хүүхдүүдийг цаашид олон янзын боловсролын байгууллага ба фирмүүдэд тараан хуваарилагдах хүртэл суулгах нэгэн байшин түрээсэлсэн байв. Тэнд монгол хүүхдүүдийг орчин нөхцөлдөө дасан идээших, герман хэл сургах ажлыг зохион

байгуулсан бөгөөд хожим С.Вольфийн дурсан бичсэнээр, олон сая хүнтэй Берлин хотод дөнгөж ирсэн хүүхдүүдэд чухамдаа хамгийн тохирох газар бол Фроонау байсан ажээ. Энд их хотын гудамж замын хөдөлгөөн, дуу чимээнээс хол, сайхан цэцэрлэгт хүрээлэнтэй байсан нь унаган байгальтай харьцаж өссөн монгол хүүхдүүдэд үнэхээр таатай байхыг хүртэл бодолцжээ. Тэр ч байтугай, Фроонаугийн байшингаас холгүй буддын шашны нэгэн сүм хүртэл байдаг байв. 1924 онд Паул Даалке гэдэг хүний үндэслэсэн бөгөөд Герман оронд байгуулагдсан буддын анхны сүм болох энэ газар хэдийгээр монгол хүүхдүүдийн эх нутаг дахь Гандан хийдийнх шиг жинхэнэ лам нар байхгүй байсан ч гэсэн бурхан тахил, танка зураг, хүж зул цөм байх бөгөөд сар бүрийн арван таванд мөнөөх Даалке гэгч өөрөө удирдан шашны зан үйл гүйцэтгэдэг байжээ (Baumann 1995: 61).



Зураг 4. Баруун Европт эрдэм сургахаар илгээсэн Монголын хэсэг охид, хөвгүүд БНМАУ-ын Ардын гэгээрлийн сайд Эрдэнэбатхаан (урд эгнээний зүүн захад сууж буй), халамжлан хүмүүжүүлэгч, багш Дэмчигийн Буддарь (хамгийн арын эгнээний гол төв хэсэгт зогсож буй), Бадамжавын Далай (баруун захад зогсож буй) нарын хамт 1926 оны зун Германы Фроонау хэмээх газар авахуулсан түүхэн гэрэл зураг

Тэгээд дараа нь Германд ирсэн монгол хүүхдүүд хэрхэн европ маягийн шинэ хувцас авч хувцасласан тухай С.Вольф багш дурсахдаа: "Би Арнольд Мюллерийн их дэлгүүрээс эхлэх санал гаргав. Дэлгүүрт орохдоо өөрийн үндэсний хөх даалимбан тэрлэгтэйгээ орсон хүүхдүүд хэдэн цагийн дараа бүрмөсөн европжоод гарч ирсэн нь Стеттинд байсныг бодвол Берлинд олны нүдэнд өртөөд байхааргүй

болов. Хөвгүүн болгон нэг нэг костюм пиджак, гурван цамц, хоёр хос өмд, оймс, зангиа зэргийг, охид мөн тохирсон хувцсаа авсан юм. Хүүхэд болгон маш том бие хүмүүс байсан нь тэд өөр өөрийн гэсэн өнгөний таашаал, төсөөлөлтэй байснаас илэрч гарав. Хүн болгоны таашаал сонирхолд нийцүүлнэ гэдэг ёстой хэцүү байж билээ” хэмээн нүдэнд харагдтал бичсэн байдаг (Wolf 1946: 77). Сергей Вольфийн хадгалж ирсэн нэгэн гэрэл зургаас богино халимагтай монгол хүүхдүүд 1920-иод оны хоёрдугаар хагасын герман залуучуудын моода-нд хэрхэн хувирсныг харж болно. Энэ зураг дээр Фроонаугийн хусан төглийн захад зуны хувцастай хөвгүүд охид халамжлан хүмүүжүүлэгч багш Д.Буддарь, Б.Далай нарын хамт байх бөгөөд хүүхдүүдийн дунд Монголын Ардын гэгээрлийн сайд Эрдэнэбатхаан зүлгэн дээр сууж байгаа харагддаг (Зураг 4).

Герман багш нар хүүхдүүдэд эхлээд герман хэл, дараа нь бусад хичээлийг заасан бөгөөд “Ева эгч” хэмээн монгол хүүхдүүдийн дотночилдог Рүдигер хэмээгч эрч хүчтэй, залуу эмэгтэй дотуур байранд халамжилж дэг журмыг сахиулж байсан аж. Ингэж монгол хүүхдүүд танил бус орчин, идэж байгаагүй хоол унд, герман хүмүүсийн зан заншилд харьцангуй түргэн дасчээ.

Эдгээр саруудад Сергей Вольф юуны өмнө Монголын Ардын гэгээрлийн сайдыг нутаг буцах хүртэл нь хувийн референтээр нь ажиллажээ. Тэрбээр Эрдэнэбатхааныг Герман орноор аялан явахад нь бараа болж, монголчууд ба германчуудын соёлын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чухал алхам болсон яриа хэлэлцээр хийхэд нь байлцсан төдийгүй тухайлбал, Бабельсберг хотоос кино үзүүлдэг проектор, камера, дэлгэц ба бусад кино гаргахад хэрэгтэй юмс, баримтат болон сургалтын кинонууд, сургуулиудад зориулсан хэвлэлийн газраас заах аргын ном, сурах бичиг ба нэвтэрхий толь худалдаж авахад нь хүртэл дагалдан явжээ. Эрдэнэбатхаан гуай Лайпциг хотноо Монголын газрын зураг хэвлүүлэх, сургуульд үзэх атлас ба монгол үсэгтэй глобус зэргийг хийлгэх тухай яриа тохироо хийж, сургуулийн хүүхэд үзэх ном барлахад хэрэг болох монгол үсгийн хэвтэй бичгийн машин хүртэл захиалсан ажээ. Түүнчлэн монгол хүүхдүүдийг цаашид сургах боловсролын байгууллагуудыг үзэж сонгох, үнэлэлт дүгнэлт өгөх ажилд Эрдэнэбатхаан сайд биеэр оролцсон бололтой байдаг. Тэрбээр Герман орноор явах үедээ хүүхдүүдийг сургахаар мэдүүлсэн нилээд хэдэн сургуулиар орж багш захирал нартай нь хүртэл биечлэн уулзаж монгол хүүхдүүдээ захиж байж. Тухайлбал, Тюринген хот дахь Викиерсдорфийн чөлөөт сургуулийн холбоонд очиж тэнд суралцах 10 хүүхдээ заавал гимназид оруулах ёстойг хэлж байсан болохыг Германы судлаач Дорис Гёттинг сурвалжлан тэмдэглэжээ (Goetting 2004: 19).

Гэвч бүх зүйл амар хялбар, шулуун дардан замаар явсангүй. Хүүхдүүдийг халамжилж байсан Дэмчигон, Далай хоёр сайдынхаа итгэл найдварыг биелүүлж чадсангүй. Санхүүгийн тогтмол бус байдлаас болж 1927 оны хавар тэднийг нутаг руу нь буцаан татсан бөгөөд Далай буцах замдаа Москвад зүрхний шигдээсээр нас баржээ.



Зураг 5. Герман, Франц улсад суралцаж байсан Монголын хэсэг хөвгүүд, охид. 1927 оны түүхэн гэрэл зураг. Дөрөвдүгээр эгнээ, босоо, зүүн гар талаас: Юмхүү (эмэгтэй), Балдангийн Содном (хожим Монголын ШУА-ийн эрдэм шинжилгээний ажилтан), Лувсандамдин (хожим барилгын инженер), Баатарсэнгэ (хожим Хэвлэх үйлдвэрийн ажилтан), Юмбүү (хожим Улаанбаатарын комбинатын инженер), Сумъяа, Пагмадулам (эмэгтэй), Гомбожав, Халаа (эмэгтэй), нэр мэдэхгүй оюутан, Баатар ван Насан-Очирын Наваан-Юндэн, Базарням, нэр үл мэдэх хүн, нэр үл мэдэх хүн, Лувсансэнгэ (хожим Радиогийн инженер), Нацагдорж (хожим инженер), Гуравдугаар эгнээ, суугаа, зүүн гар талаас: Сурмаа (эмэгтэй, хожим Улсын номын сангийн ажилтан), Дашидоржийн Нацагдорж (алдартай зохиолч), Чимэд, Дэмчигийн Буддарь, Бат-Очир (доктор), Батсүх (эмэгтэй, хожим БНМАУ-ын ардын багш), Цэрэнханд (эмэгтэй, хожим Улсын номын сангийн ажилтан), Гомбо (хожим инженер), Хоёрдугаар эгнээ, газар сууж байгаа, зүүн гар талаас: Содном, Бавуу (хожим Техникумын багш), Лувсан (хожим багш), Цэцэг (хожим геологич), Бадарч, Пүрэвдорж, Доржсүрэн (хожим багш), Цэдэд (хожим багш), Нэгдүгээр эгнээ, зүүн гараас: Донровын Намдаг (хожим БНМАУ-ын төрийн шагналт, алдартай зохиолч), Цэвээн (хожим химич, уурхайн мэргэжилтэн) (Р.А. Рупен 2000: 201).

Буддарь тухайн үед хир нэр нөлөө бүхий хүн байсан нь түүний шавь нарын багшидаа бичиж байсан захидал, дурсамжаас илэрхий байдаг. Тухайлбал, 1927 оны нэгдүгээр сарын дундуур Германд нэмэгдэн ирсэн дөрвөн монгол сурагчийн нэг болох Лувсанцэндээс Буддарь багшидаа германаар бичсэн нэгэн захидлаас монголчилбол: “Хайрт багш Дэмчигон Таныхаа амар амгаланг айлтгая. Би сайн байна. Тэд маань ч бас энд сайн байгаа. Сургууль дээр өдөрт 6 цаг хичээл хийж, долоо хоногт нэг удаа усанд орж байна. Орой 10 цагт унтахаар явж, өглөө 6 цагт босдог. Өдөрт 5 удаа хооллож, өглөө бүр, бас Пүрэв гаригт өрөөгөө цэвэрлэдэг. Сургууль дээрээ юу хийж байна хэмээн Та асуужээ. Би өглөө даваа гаригаас эхлээд

8 цагт сургууль дээрээ ирж ангидаа суудаг. Эхний цагийн хичээл унших, дараа нь тоо бодлого, гуравт бичгийн ажил, дөрөвт нот унших ба дууны хичээл, тавдугаар цаг дахиад бас бичгийн хичээл, зургаадугаар цаг хөдөлмөрийн хичээл байдаг ... Цэвэг бид хоёр нэг өрөөнд хамт, Юмхүү хоёр герман охинтой нэг өрөөнд, Сурмаа бас адилхан сууж байна. Өөр онцын хэлэх зүйлгүй. Дараа өдөр баяртай уулзъя” гэжээ (Goetting 2004: 46). Үүнээс үзэхэд Буддарь багш сурагчиддаа байнга халамж анхаарал тавьдаг, тэгэхдээ бүр хол байгаа заримтай нь тухайн улсын хэл соёлыг аль болох түргэн сургахын үүднээс тэр улсынх нь эх хэлээр бичиглэн харилцаж байсан нь харагдана.

Ардын багш Г.Батсүх агсан: “Буддарь, Далай гэдэг хоёр багш биднийг Германд авч очсон. Бидний хоолны мөнгө Монголоос гуйвж очдог байсан юм уу даа. Тэгтэл Далай багш маань бидний хоолны мөнгийг аваад алга болчихов. Буддарь багш тэндхийн цагдаагийн байгууллагын тусламжтайгаар Далай багшийг эрсээр байж олжээ. Тэр бидний хоолны мөнгөөр наргиж цэнгэсээр Берлинээс зайдуу нэгэн хотод очиж герман хүүхэнтэй суугаад Америкт гарчих бодолтой байжээ. Гэтэл Буддарь багш Далайг олж эгүүлсэн хирнээ чухам юунаас болсон юм өөрийгөө буудаад эмнэлэгт хэвтэж төдий л удаагүй эдгэрсэн юм. Далай багшийн татагдаж буцахад түүний оронд Монголоос Ишдорж багш очсон. Буддарь багш бидэнд маш их анхаарал халамж тавьдаг сайн багш байсан. Нэг удаа Төмөрийн Нацагдорж байрандаа тамхи татаж шаардлага тавьсан багштай эвгүй харилцсанаас болоод сургуулиасаа хасагдахад хүрэв. Хичээлд нь ч оруулахаа больчихлоо. Тэглээ ч гэсэн Буддарь багш хоёр сар шахам хөөцөлдөж дээгүүр доогуур ярьж гуйсны хүчээр уг шийдвэрийг нь өөрчлүүлж Т.Нацагдоржийг хичээлд нь оруулж билээ. Ер нь тэгээд би ч гэсэн Германаас ирээд Буддарь багшийнхаа тус дэмээр багшийн ажил хийж эхэлсэн юм. Багш маань газарзүй, байгалийн шинжлэл, түүхийн олон сайхан номтойсон. Надад герман хэл дээр хэвлэгдсэн хэд хэдэн сайхан ном бэлэглээд “Чи энэ номуудыг уншиж хичээлийн хэрэглэгдэхүүн болгохоос гадна зарим чухал гарчгий нь орчуулж багш нарт тусламж болгон нийтлүүлээрэй” гэж билээ. Гэтэл би 30-40-өөд оны үед герман номноос орчуулж нийтлүүлэх байтугай өнөө номуудаа энд тэнд газрын мухарт нууж далдалсаар үрэн таран хийчихсэн. Хайран номууд! Үнэндээ тэр үед Буддарь багш над тийм тийм герман ном өгсөн гэж дэл сул яривал Дотоод яамны хараанд орж сэжиглэгдэх байсан даг шүү. Би нэг удаа Буддарь багштай суртлын бригадаар явсан юм. Багш хими физикийн сонин туршлага хийж үзүүлж тайлбарлахын зэрэгцээ ноёны хувцас өмсч нүүрээ танигдахааргүй болтол будаж янзлаад “Өвгөн феодалын үг” гэдэг шүлэг уншдагсан. Манай Буддарь багш олон хэл мэддэг, тал бүрийн өндөр боловсролтой, уур уцааргүй тун эелдэг зантай сайхан хүн байсан юм. Ер нь тэр үеийн залуу багш нар Ишдорж, Буддарь хоёр багшаас л тун их заавар зөвлөлгөө авдаг байлаа” (Чойжамц 1996) хэмээн дурсан ярьсан нь Буддарь тухайн үедээ ямаршуу нөлөөтэй хүн байсныг үзтэл илэрхийлж байна. Гадаад улсын сургуульд удаа дараа явуулсан хүмүүсийн нэр, нас зэргийг тодорхойлсон архивын баримтанд Д.Буддарийн тухай тэмдэглэснийг сонирхуулбал:

ДЭМЧИГИЙН БУДДАРЬ (1894-1939)

Дараалсан дэс дугаар	57
Нэрс	Будадари
Нас	31
Аймаг хошуу	Богд хан уулын аймаг
Аль улсын ямар нэртэй хотноо	Герман Берлин
Ямар сургууль төгсөхөөр	Хэл бичиг, түмэн бодис урлах
Хэзээ сургуульд орсон	15 он (1925) 10 сар
Хэзээ сургуулиас хасагдсан	
Ямар учир хасагдсан	

гэсэн байна (МУҮТА, Ф-6, Д-1, ХН-40: 25). Эдгээр баримтаас үзэхэд Буддарь багш 1926 оны зун гучин гурван (32) настай Германд яваад 1927 оны хавар гучин дөрвөн (33) настайдаа Монголд буцаж ирсэн бололтой. Үүнийг ч 1927 онд Герман, Францад суралцаж байсан монголын хэсэг охид, хөвгүүдийн нэгэн гэрэл зураг гэрчилж байна. Бид зураг дээр Д.Нацагдорж, Д.Чимэд, Д.Буддарь, Гомбожав, Содном, Наваан-Юндэн зэрэг нилээд хэдэн хүнийг таньж байгаа боловч бүгдийг нэрлэж үл чадна (Зураг 5). Эл гэрэл зураг дээрхи хүмүүсийг нэг бүрчлэн тодруулбал, хойч үеийнхний танин мэдэх үйлсэд тустай хэмээн үзнэ. Иймд мэргэн уншигч Та өөрийн мэддэг хүнийг нэрлэн зааж захиа ирүүлнэ гэдэгт найдна (Идшинноров 1992).

Ер нь Д.Буддарь багшийн 1920-иод оны сүүл 30-аад оны эхэн хагаст холбогдох намтрын мэдээ баримт ихээхэн ээдрээ будлиантай, цаашид лавшруулан тодруулмаар зүйл ихтэй байгааг тэмдэглэх хэрэгтэй. Дуун хөрвүүлэгч Амар гуайн сурвалжлан нийтлүүлсэн орос хэлээрх архивын баримтаас үзэхэд, Димчигон Буда-Дари 1894 онд төрсөн, уг нутаг нь Агын аймгийн Цүүгэл сум, аль улсын харьяат вэ гэдэг асуултанд БНМАУ-ын харьяат, Улаанбаатар хотод суудаг, эрхэлдэг ажил нь Улаанбаатар дахь Багшийн сургуулийн багш, гарал үүсэл нь нударган, эцэг Дэлгэрийн Дэмчиг нь Хаант засгийн үед сумын дарга байсан, Буддарийн эхнэр Намсрайн Ханджав 29 настай, эмнэлгийн сувилагч, хадам эх 60 настай Цэгмид хүргэний асрамжинд байдаг, Буддарь нь Харбин хот дахь генерал Хорватын нэрэмжит Төмөр замын институт төгссөн, 1923-1929 он хүртэл МАХН-ын гишүүн байснаа нийгэмд харш этгээд хэмээн хөөгдсөн, 1924 онд Улаанбаатарт байхдаа мөнгө үрэгдүүлсэн хэрэгт баривчлагдаад 3 сар шоронд суухаар шийтгэгдээд 3 хоноод суллагдсан, 1936 онд БНМАУ-ын Засгийн газраас Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнуулсан гэсэн байна (Амар 2003: 17).

Дашрамд дурдахад, Буддарь багш Германаас буцаж явах замдаа 1927 оны 6 сарын 6-ны өдөр Монгол-Оросын хил дээрх Троицкосавск хотноо нэг нутгийн буриад, нэрт жуулчин, угсаатны зүйч, хэлний шинжлэлтэн Цэвэгийн Гомбожав (1873-1930)-тай таарч, “Сибирь” хэмээх зочид буудалд нэг өрөөнд хамт хоносон байдаг. Энэ тухай Ц.Гомбожав аян замын тэмдэглэлдээ: “Энд би Германаас буцаж явсан Б.Д.Димчиковтой таарч хамт нэг өрөөнд хонов ... Димчиков надад ардын мөнгө (2 мянга орчим) үрэгдүүлж амьдралын замналаа гутаасан тухай ярилаа.

Тэрбээр шоронд орж 2 жил суух байх гэж айж байгаа боловч хохирлыг нь барагдуулчихвал сургуульд багшлах боломж өгнө байх хэмээн найдаж буйгаа хэлэв. Ийм төгсгөл түүнд илүү таалагдаж байсан бөгөөд эцэг эх нь суурь сууриар олон янзын малтай учир 2000 рублийг хялбархан төлчих ажээ*. Тэр цээж нуруун дээрх шархаа үзүүлээд хэлсэн нь, сум зүрхнээс нь доогуур 1 сантиметр зайтай өнгөрч уушгийг нь нэвтлэн гарсан. Эмчилгээ их сайн болсон. Нилээд хэдэн удаа уушгаа цэвэрлүүлээд одоо бүр илааршиж байна гэв. Би түүнээс яаж төдий их хэмжээний мөнгө үрэн таран хийдэг байна хэмээн асуув. Тэр хэд хэдэн хотод сууж байсан ба авч байсан тэтгэлгээсээ илүү мөнгө зарахад хүрсэн. Одоо гэр бүлийн нам гүм амьдралыг, тэгэхдээ заавал герман эхнэртэй байх тийм амьдралыг эрмэлзэж байна гэв. Тэр германы аж ахуйг шагшин гайхаж байсан. Хүн амын тооны хувьд эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдийн харьцаа 100:80 болсон. Ажлын дийлэнхийг эмэгтэйчүүд хийдэг. Дайны харгайгаар герман хүмүүсийн ерөнхий өсөлт ийм болсон гэж ярих хэмээн бичсэн байдаг (Цыбиков 1991:150).

Үүнээс үзэхэд Германд байхдаа албаны мөнгө үрэгдүүлсэн хэрэгт орооцолдсондоо Буддарь багш үнэхээр харамсаж байсан бөгөөд өөрийн нэр төрийг сэвтүүлсэн явдал хэмээн үзэж байсан тул амиа хорлохыг завдсан нь үнэнтэй юм. Энэ тухай дам яриаг сонсоход, Буддарь хүүр оршуулахад хэрэглэдэг цаасан уут аваад, бас дэлгүүрээс шил архи авч. Тэгээд архи ууж зүрхээ чангалаад уутан дотроо орж өөрийгөө буудсан гэнэ. Гэвч буу шийдэмд эв дүй муутай байснаас уу, эсвэл архи ууж согтсоноос тэрүү амин газраа онолгүй хөнгөн шархадаад удалгүй эдгэсэн ажээ. Р.Ч.Эндрюс, Ч.Галленкамп нарын хүнээс дам сонссоноо бичсэнээр бол тухайн үед Далай биш Буддарь улсын мөнгийг шамшигдуулсан гэж ойлгохоор байдаг. Гэтэл тэр үед Буддарь, Далай нарын удирдлагын дор Герман оронд хамт суралцаж байсан монгол хүүхдийн нэг Г.Батсүх багшийн батлан хэлснээр мөнгийг Буддарь биш, харин түүнтэй хамт ажиллаж байсан Далай багш үрэгдүүлсэн болж байна. Үүнийг ч мөн архивт хадгалагдаж байгаа тэр үеийн зарим баримт нотлон харуулж байх бөгөөд тухайлбал 1927 оны хавар Берлины Фроонау хэмээх газраас Ишдорж багшийн гараараа бичсэн нэгэн цахилгаанд: “Буддарь эдгэрч өнөөдөр ирэв. Далай албаны мөнгө үрсэн нь үнэн бөгөөд үлдсэнийг нь үл тушаамой. Далайд буй мөнгийг шилжүүлж ав гэсэн дойчэ үсгийн бичиг даруй ирүүлсүгэй” (МУУТА, Ф-6, Д-1, ХН-154: 75) гэсэн байдаг.

Бидний санавал, Буддарь багшийн талаар Засгийн газрынхаа даалгавраар өөрсдийг нь тагнаж худал матаас мэдээлэл өгч байсан өөдгүй хүн гэсэн сөрөг муу бодолтой байсны дээр, өөр хүнээс дам сонсож дуулснаа ямар ч баримт нотолгоогүй бичсэн гадаадын эрдэмтдээс тэр үед Герман оронд хамт байж болсон хэрэг явдлыг нүдээр үзсэн амьд гэрч болох сурагч, хамтран ажиллагч мэргэжил нэгт багш хоёрын нь өчсөн мэдүүлэлт үнэний хувьтай болов уу. Харин нэг нутаг усны хуучин танил Ц.Гомбожав буюу Г.Ц.Цыбиковтой Хиагтын зочид буудлын өрөөнд хамт хонохдоо

* Үнэхээр Буддарь багшийнх тухайн үед мал хөрөнгө сайтай айл байсан нь 1930 оны архивын баримтад ам бүл дөрөв, 365 толгой бод малтай гэж бүртгэгдсэнээс илэрнэ (МУУТА, Ф-6, Д-2, ХН-52: 114).

Буддарь багш, мөнгийг би биш харин Далай үрэгдүүлсэн юм гэж шууд хэлээгүйгээс үзэхэд, тэрбээр энэ хэрэгт бас өөрийгөө ямар нэг хэмжээгээр буруутай гэж мэдэрч гэмшиж байсан бололтой. Тийм ч учраас Японд хэсэг хугацаанд сурч байсан ба тэр орны зан заншлыг сайн мэддэг болсон Буддарь багш гэм нүглээ цагаатгах гэж харакири хийдэг самурай ёсоор өөрийгөө егүүтгэн цагаатгахыг бодсон ч юм билүү?

Бидний олж мэдсэнээр 1929 онд МАХН-ын хоёрдугаар цэвэрлэгээгээр хэтэрхий хөрөнгөтэй (МУҮТА, Ф-6, Д-2, ХН-52: 114, 169) хэмээн намаасаа хөөгдсөний дараа Д.Буддарь нэг хэсэг нутаг заагдан Хан Хэнтий аймгийн Халх голын хошууны Могойт сумын (одоогийн Дорнод аймгийн Халх гол сум) тэнхимийн бага сургуульд багшилж байгаад дараа нь Улаанбаатар хотноо шилжин ирж Багш нарыг бэлтгэх сургуулийн багш (архивын баримтад тэмдэглэснээр сарын 140 төгрөгийн цалинтай цагийн багш) болсон бололтой (МУҮТА, Ф-6, Д-2, ХН-23: 77-78; Ф-6, Д-2, ХН-24: 5-6). Энэ тухай тэр үед сургуулийн сурагч явсан шавь нар нь ч дурсан ярьж байсан бөгөөд Дорнодоос Улаанбаатарт дунд сургуульд орохоор ирсэн хүүхдүүд сурлагын амжилт, мэдлэгийн хүрээ, уншсан дуулсан зүйлээрээ үе тэнгийнхнээсээ онцгой ялгарч байсан нь чухамдаа хөдөөгийн бөглүү суманд Буддарь мэтийн өндөр боловсролтой, тал бүрийн авьяастай сурган хүмүүжүүлэгч, багш нар ажиллаж байсантай холбоотой юм.

Эдүгээ Монгол Улсын Үндэсний Төв Архивт хадгалагдаж буй Улаанбаатар дахь Багш нарыг бэлтгэх сургуулийн багш ажилчдын тухай 1934 онд тэмдэглэсэн нэгэн баримтанд: “Дэмчигийн Буддарь. Нас 40. Багш нарыг бэлтгэх сургууль. Ард. Бус (намын гишүүн). Багш. 13 оноос эхлэн оюутан ба багш. Дунд сургуулийн багш, захирлын ажил, франц, германы багшаар 13 жил болжээ” (МУҮТА, Ф-6, Д-2, ХН-188: 34-35) хэмээн бүртгэсэн байх ба Ардыг гэгээрүүлэх яамны харьяа байгууллагаас улс хувьсгалын 15 жилийн ойн баяраар Улсын Бага Хурал ба Ардын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор төрийн дээд зэргийн гавьяа шагнал хүртсэн хүмүүсийн жагсаалтын нэгдүгээрт: “Дэмчигийн Буддарь – аж ахуйн гавьяаны одон шагнагдсан” хэмээн тэмдэглэсэн байна (МУҮТА, Ф-6, Д-2, ХН-188: 41).

Буддарь багш Монголын ард түмнийг дэлхийн соёл боловсролтой танилцуулж олон оронд дэлгэрсэн сурах бичиг ба сонгодог зохиолуудаас эх хэлэндээ орчуулах ажлыг эрчимтэй хийж байсан бөгөөд тухайлбал, канад зохиолч Э.Сетон-Томпсоны “Лобо чоно” зэрэг амьтны өгүүллэгийг орчуулан хэвлэж байсан мэдээ байна. Түүнчлэн 1930-аад оны үед БНМАУ-д бичиг үсгийн шинэчлэл хийж, бүх нийтийг бичиг үсэгт сургах ажил өрнөхөд тэрбээр идэвхтэй оролцож өөрийн саналыг нэмэрлэж явсан баримт ч бий. Кирилл үсгийг хэдхэн оронд хэрэглэдэг тул монголчууд шинэ үсэг авбал латин үсэг хамгийн тохиромжтой хэмээн үзэж байсан Буддарь багш монголын хэл аялгуунд зохицсон авиа үсэг тэмдэглэх латин цагаан толгой зохиосон байна. Тэрбээр 1930 онд өөрийн шавь, их зохиолч Д.Нацагдоржийн хамт “Залуучуудын үнэн” сонинд “Соёлын хувьсгалыг шулуун замаар хөгжүүлье нөхдүүдээ!” хэмээх асуудал дэвшүүлсэн судалгааны өгүүлэл бичиж нийтлүүлжээ. Уг өгүүлэлд латин үсгийн цагаан толгой, зөв бичих зүйд буй дутагдлуудыг дурдан латин үсгийг авахдаа өөр үсэгтэй хольж хэрэглэхийг аль

болох цээрлэх, монгол хэлний нэг авиа, сонгодог бичгийн хэлний нэг латины давхар үсэг, нэмэлт тэмдэгтэй үсгээр тэмдэглэхээс аль болох зайлсхийх зэрэг зарчмын зургаан санал дэвшүүлсэн нь Монгол оронд латин үсгийг авч хэрэглэх тухай ид яригдаж, анхны туршиц оролдлогуудыг хийж байсан үед олны анхаарлыг ихэд татсан бүтээл болж байжээ (Очир, Дашням 1996: 122-125).

Үүнээс гадна Буддарь багш түүх, газарзүй, угсаатан судлал, байгалийн шинжлэл, тоо бодлого, уран зохиол, хими, физик, одон орон судлал зэрэг олон салбарын судалгаа, түүний дотор нэн ялангуяа палеонтологи, археологийн анхны шинжилгээг эх орондоо бие даан хийж байсан монгол судлаач ажээ. Тэрбээр бүр 1925 онд Америкийн Байгалийн Түүхийн Музейн Төв Азийг судлах гуравдугаар экспедицийн бүрэлдэхүүнд Монголын шинжлэх ухааны байгууллагын томилолтоор ажиллаж байхдаа зоологи, археологийн холбогдол бүхий 3 хайрцаг олдвор цуглуулж байсан мэдээ буй бөгөөд хожим орон нутгаас чулуун зэвсгийн голдуу олдвор хэрэглэгдэхүүнийг цуглуулан Улаанбаатар хотноо Шинжлэх Ухааны Хүрээлэнд өгч байсан байдаг юм.

Энэ тухай нутгийн ах дүү нар нь дурсахдаа: “Намайг арван хэдтэй байхад Буддарь ах Халх голын ойролцоох уул хадаар яваад манай гадаа ирж аавтай уулзахдаа ганзагалж яваа уутнаасаа хэсэг чулуу гаргаад, эвлүүлэн тавихад нь яг сүхний дүрстэй болчихож билээ. Түүнийхээ талаар аавд тайлбарлах маягаар юм яриад л байсан, чухам юу ярьсныг мэдэх юм алга” хэмээн нутгийн настан Г.Цэнд гуай өгүүлсэн бол түүний зээ, бэлтгэл хурандаа Б.Цэрэн гуай: “Бас Буддарь ах нэг дуран авай авч явсан, түүгээр нь харахад энгийн нүдэнд огт харагдахгүй байгаа адуу мал харагдсан. Хонхор газрыг товойлгон харагдуулдаг дуран авайг анх үзсэн минь тэр гэж эгч маань ярьдаг. Тэр бол Буддарь гуай амралтаараа аав ээж, ах дүү нарынхаа нутаглаж байгаа Халх голын нутагт очсон үе нь бөгөөд тэрбээр элдэв чулуун зэв, зэр зэвсгийн зүйлээс гадна ямар нь мэдэгдэхгүй амьтны яс цуглуулаад Улаанбаатар руу буцсан (Амар 2003: 14).

Буддарь нагац 1929, 1932, 1933 онуудад хөдөө гэртээ очиж байсан. Тэр үед түүний өвөг эцэг Дэлгэр, өөрийн нь эцэг Дэмчиг нар цөм Дорнод аймгийн Цагаан-Овоо суманд амьдарцгааж байсан юм. Тэднийхэн мал олонтой байсан юм. Нагац сүүлийн удаа 1936 онд эхнэр хүүхэдтэйгээ очиж билээ. Базарханд гэдэг хүүтэй байсан. Буддарь нагац хөдөөгүүр явж ан хийхээс гадна амьтны яс, элдэв янзын чулуу цуглуулж түүнийгээ цэвэрлэж их л нандигнан савлаж аваад явдаг байсан. Чухам ямар амьтны яс, ямар чулуу цуглуулж байсныг би бага байсан учраас мэдсэнгүй. Одоо бодоход нагац маань байгалийг сонирхон судлагч хүн байжээ” (Чойжамц 1996) хэмээн дурсан ярьсан байдаг.

Ахмад орчуулагч Амар гуайн бичсэнээр, Монголын нэрт эрдэмтэн, түүхч академич Ш.Нацагдорж агсан түүнийг Улсын их сургуульд сурч байхад хичээл заадаг байжээ. Нэг удаа оюутан нар: “Хувьсгалаас өмнө манай оронд археологийн судалгаа байсан уу” гэж асуухад Ш.Нацагдорж гуай: “Буддарь багшийн Халх голоос олж цуглуулсан нилээд зүйлийг эс тооцвол өөр тоймтой юм байхгүй” гэж хариулсан бөгөөд цааш дэлгэрүүлэн ярихдаа “Голын музейд (Богд хааны музей

гэхээс Голын музей гэдэг байсан үе) байгаа эртний монголчуудын тэрэгний цөн, эмээл хазаар, чулуун зэвсгийн үеийн зүйл бол чухамхүү Буддарь багшийн цуглуулсан зүйл юм шүү дээ” гэж хэлж байжээ (Амар 2003: 13-14). Үүнийг тухайн үед Монголын Шинжлэх ухааны хүрээлэнгийн урилгаар ирж ажиллаж байсан гадаадын эрдэмтдийн бичсэн зүйл ч давхар баталж байх бөгөөд тухайлбал, Өмнөговийос Даш, Дорнодоос Буддарь нарын хүмүүс чулуун зэвсгийн олдвор цуглуулан илгээж байсан тухай 1933-1934 онд Монголд ажилласан Зөвлөлтийн эрдэмтэн Д.Д.Букинич тайландаа нэр заан тэмдэглэсэн байдаг (Букинич 1934: 4).

Ялангуяа Буддарь багш бол тэр үеийн өндөр боловсролтой сэхээтний нэг байсны хувьд Шинжлэх ухааны хүрээлэнд судалгааны анхдагч эх хэрэглэгдэхүүн буй болгох, улмаар эх орны түүхийн чухал ач холбогдол бүхий музейн үзмэрийг бүрдүүлэх талаар онцгой анхаарч ажиллаж байжээ. Буддарь багшийн шавь нарын нэг, хожим манай улсын нэртэй дипломатч болсон Б.Жаргалсайхан агсны дурссанаар, түүнийг хошууны тэнхмийн сурагч байхад нь Халх гол, Тамсаг булаг, Хэрээ уул орж сурагчдын хамт чулуун зэвсэг цуглуулж, музейд илгээж байсан гэдэг. Хожим тэрбээр багшийнхаа мөрөөр аялж Оросын нэрт эрдэмтэн, академич А.П.Окладниковт эдгээр газрыг заан өгч чулуун зэвсгийн алдарт олбороо нээхэд нь тусалсан ажээ (Жаргалсайхан 1995: 107). Буддарь багшийн 24 оны тэр цуглуулгын зарим нь Улаанбаатар хотод Монголын Үндэсний Музейн сан хөмрөгт одоо ч байдаг юм (Эрдэнэбат, Эрдэнэбат 2008: 7-8). Энэ бүх баримтаас үзэхэд Д.Буддарь багш Монгол улсад үндэсний археологийн шинжилгээ хөгжих үндсийг тавьж, холбогдох эд зүйлсийг цуглуулан, улсын сан хөмрөгт оруулж явсан, Монголын эртний судлалын шинжлэх ухааны тулгын чулууг тулалцсан хүний нэг юм хэмээн ойлгож болохоор байна.

Гэвч харамсалтай нь Монгол оронд өрнөсөн улс төрийн аймшигт хилс хэлмэгдүүлэлтийн хар дайрлага манай эх орны олон зуун шилдэг охид, хөвгүүдийг дайрсны нэгэн адил тухайн үеийн Монголд хуруу дарам тоологдох өндөр боловсролтой сэхээтний нэг Д.Буддарь багшийн хувь заяа уршигт хэлмэгдүүлэлтийн сүүдрээс тойрч гарсангүй. Зээ Б.Цэрэнгийн ярьснаар бол 1937 онд Буддарь жанжин Дэмидийн хамт ЗХУ-ыг зорьж яваад Тайга өртөөнд хортой хоол идэж хордсоноос эмнэлэгт хэвтэж эмчүүлээд улмаар Кисловодск хотод амарч байсан бололтой (Чойжамц 1996). Тийнхүү сувилуулж байсан Буддарийг 1937 оны 9 сарын 25-ны өдөр Зөвлөлтийн Дотоод яамнаас баривчилж 1939 оны 2 сарын 13-нд СССР-ийн Дээд шүүхийн Цэргийн коллегийос Эрүүгийн хэргийн Тусгай ангийн 58б, 58.8, 58.11 дугаар зүйл ангийн дагуу буруутган шийтгэж буудан алах ял оноогоод мөн оны 3 сарын 7-нд уг ялын тогтоолыг гүйцэтгэснээр эрдэм соёлыг түгээн дэлгэрүүлж Монголын залуу үеийг сурган хүмүүжүүлэх үйлст хүчин зүтгэж явсан, дэлхийн боловсролын шимийг хүртсэн нэрт сэхээтэн Буддарь ид бүтээн туурвих дөчин зургаан (45) насандаа туйлын харамсалтайгаар хөнөөгджээ.

ЗСБНХУ-ын Дээд зөвлөлийн Цэргийн коллегий Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын нэрийн өмнөөс ялласан шийдвэрт: “БНМАУ-ын харьяат, яс үндэс буриад, том нударган ноёны хүү Дэмчигийн Будадарийг ЗХУ-ын

Эрүүгийн хуулийн заалтын дагуу ялласугай” гээд урьдчилсан мөрдөн байцаалтаар Димчигон Будаари нь 1920 оноос эхлэн Японы тагнуулын байгууллагуудын гишүүн болсон, 1923 оноос эхлэн хувьсгалын эсэргүү явдлын ба Япон-Буриадын үндсэрхэг үзэлт-бослого гаргах байгууллагад оролцож эхэлсэн, Японы тагнуулын байгууллагуудын даалгавраар тагнах, бослого гаргах, алан хядах ажиллагаанд зориулан ЗСБНХУ-ын нутагт Зөвлөлтийн эсрэг ажиллагаа явуулах шинэ хүмүүсийг элсүүлэх ажил зохиож байсан. Димчигон нь 1937 онд Зөвлөлт улсад ирээд Москвад байгаа хувьсгалын эсэргүү үндсэрхэг байгууллагынхантай холбоо тогтоож, тэр байгууллагад оролцогчдын нэгэн болох Ишдоржоор дамжуулан Бүх Холбоотын Коммунист Большевикуудын Намын ба Зөвлөлт Засгийн газрын удирдагчдын эсрэг алан хядах ажиллагаа явуулах террорист бүлгүүдийг зохион байгуулахыг оролдсон хэмээн ялласан нь Монголын Багшийн сургуулийн багш хорхойд хоргүй хөөрхий нэгэнд дэндүү томдсон, хэтэрхий эмгэнэлтэй, даан ч хилсдүүлэн гүжирдсэн улс төрийн аллага байлаа. Тэрхүү Цэргийн коллеги гэгч нь Димчигон Будаарид эрүүгийн шийтгэлийн дээд хэмжээ буудан алах ял оноогоод аминд нь ноогдох бүх хөрөнгийг хураасугай гэж тогтоосон ажээ (Амар 2003: 17-18).

Уулын чинээ харыг туулайн чинээ цагаан дийлдэг гэгчийн үлгэрээр шударга үнэн ялан дийлж, нэгэн үеийн харгис бурангуй цагийн шуурганд хилсээр хэлмэгдэн хороогдсон Дэмчигийн Буддарь 1990 оны 3 сарын 29-ний өдөр мөнөөх ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн тогтоолоор цагаатгагдаж ариун цагаан нэр төрийг нь сэргээсэн юм. Буддарь багшийн садан төрлийн хүмүүс, ах дүүгийн нь хүүхдүүд эдүгээ Монгол Улсын Улаанбаатар хот, Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутагт энх тунх аж төрж, нэр төртэй ажиллаж хөдөлмөрлөж байна. Түүний төрсөн ах Дэмчигийн Юндэнгийн зээ охин Үржингийн хүүхэн Бодонгууд овогт Минжингийн Болорцэцэг нагац өвгийнхөө хүсэл мөрөөдлийг биелүүлж палеонтологич хэмээх эрхэм мэргэжлийг эзэмшсэн бөгөөд 2006 онд Америкийн Нэгдсэн Улсад палеонтологийн ухааны докторын зэрэг хамгаалжээ.

Д.Буддарь багш бол Монголын шинжлэх ухаан, шинэ үеийн соёл боловсролын цаашдын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж чадах авъяаслаг зүтгэлтэн байсан нь ямар ч эргэлзээгүй бөгөөд энэ хүний гэгээн дурсгалыг мөнхжүүлэх, гайхам амьдралынх нь намтрыг судлах шаардлагатай байна. Түүхийг нэгэнт хүмүүс бүтээдэг тул түүнийг зөв ойлгохын тулд тухайн үеийн түүхийг бүтээлцсэн бие хүмүүсийн намтрыг судлах нь чухал ач холбогдолтой. Тэгэхдээ заавал тухайн орон, цаг, ахуйтай нь холбож хэдүйд, хаана, хэрхэн буй болсныг анхаарах ёстой билээ (Дамдинсүрэн 1957: 5).

Бид энэхүү өгүүлэлдээ Монгол улсын Үндэсний Төв архивын номын сан, гадаад улсын сургуульд удаа дараа явуулсан хүмүүсийн нэр, нас зэргийг тодорхойлсон данс, Улаанбаатар дахь Багшийн сургуулийн багш нарын бүртгэл хийгээд Герман улсад ажиллаж байхдаа Москва хотод буй Элчин сайдын газартай харилцаж байсан цахилгаануудаас Д.Буддарь багшид холбогдохыг нь сурвалжлан олж, анх удаа хавсралт болгон нийтлэв. Цаашид Д.Буддарь багшийн Судар бичгийн хүрээлэнд ажиллаж байсан үеийн болоод хожмын бүтээлүүдийнх нь талаар

судалгааг гүнзгийрүүлэн явуулах шаардлагатай байгааг ахин дурдахыг хүсэж байна. Мөн ОХУ, Германы архивт хадгалагдаж буй баримтуудтай танилцаж Д.Буддарь багшийн намтар болоод эрдэм шинжилгээний ажилд холбоотой шинэ сонин эх хэрэглэгдэхүүнийг сурвалжлан олж судалгааны эргэлтэнд оруулах боломжтой гэдэгт итгэж явдаг. Түүгээр ч барахгүй энэ хүний туулж өнгөрүүлсэн ээдрээтэй амьдрал, эрдэм номын төлөө дэлхийг тойрсон адал явдалт түүх, эмгэнэлт хувь заяаны нь тухай өгүүлсэн кино зохиол бичиж, тэр үеийн Монголын болон дэлхий дахины түүхийн үйл явцтай холбон харуулсан тайз дэлгэцийн уран бүтээл туурвих аваас лав Холливудын энэ төрлийн адал явдалт киноноос огтхон ч дутахааргүй сонирхолтой сайхан бүтээл болно доо гэсэн сэтгэгдэл төрдөг юм.

НОМ ЗҮЙ

Амар Г., 2003. Эгэл эрхмүүд. УБ.

Букинич Д.Д., 1934. Общий отчет по археологическим работам за 1933 и 1934 год. Рукописный фонд Института Археологии Академии Наук Монголии. Ф.9, Т. II, ХН. 23.

Дамдинсүрэн Ц., 1957. Монголын уран зохиолын түүх (XIII-XVII зууныг хүртэлх үе). Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо, Мүгдэн (уйгуржин монгол үсгээр).

Жаргалсайхан Б., 1995. Олон жилийн хууч. Элчин сайдын тэмдэглэл. Улаанбаатар.

Иошинноров С., 1992. Гэрэл зурагт буусан түүх. “Түүхийн хүрд” сонин. №1 (2), УБ, XVII жарны төмөр хонин жилийн өвлийн сүүл сарын цагаан хулгана өдөр.

Монгол-Зөвлөлтийн соёл, шинжлэх ухаан, техникийн харилцаа (1921-1960), 2000. Монгол Улсын Үндэсний Архивын Газар, Оросын Төрийн Архивын Алба (РОСАРХИВ). Редакцийн зөвлөл: О.Батсайхан, Х.Энхтүвшин, В.П.Козлов, И.И.Кудрявцев, Эмхэтгэгчид: Х.Энхтүвшин, Д.Цэдэвсүрэн, Х.Хишигт, Ж.Гэрэлбадрах, М.Байгальмаа, И.И.Кудрявцев, Т.П.Колтович, Г.И.Слесарчук, С.М.Розенталь, Э.Н.Шахназарова. УБ.

Монгол Улсын Үндэсний Төв Архив, Ф-6, Д-1, ХН-40.

Монгол Улсын Үндэсний Төв Архив, Ф-6, Д-1, ХН-154.

Монгол Улсын Үндэсний Төв Архив, Ф-6, Д-2, ХН-23.

Монгол Улсын Үндэсний Төв Архив, Ф-6, Д-2, ХН-24.

Монгол Улсын Үндэсний Төв Архив, Ф-6, Д-2, ХН-52.

Монгол Улсын Үндэсний Төв Архив, Ф-6, Д-2, ХН-188.

Очир А., Дашнян Г., 1996. Д. Нацагдорж: Нийгэм, улс төр, эрдэм судлалын үйлс, амьдрал. УБ.

Рупен Роберт А., 2000. Хорьдугаар зууны монголчууд. Англи хэлнээс орчуулсан Хатагин Г. Аким. УБ.

Сэрээтэр Ч., Цэрэв Х., Чадраа Б., 2002. Монгол улсын Шинжлэх Ухааны Академийн түүх. УБ.

Чимитдоржиев Ш.Б., Раднаев Б.О., Бадмажапов Б.В., 2006. Цокто Бадмажапов – Первооткрыватель “мертвого” города Хара-хото. Библиотека журнала “Тайны Бурятии”. Улан-Удэ.

Чойжамц Д., 1996. Эрдэм сурахаар дэлхийг тойрсон нь. “Ил товчоо” сонин. №24 (208), УБ, 1996, 08.21-31.

Цыбиков Г.Ц., 1991. Дневник поездки в Ургу в 1927 г. В кн.: Г.Ц.Цыбиков. Избранные труды в двух томах. 2-е издание, переработанное. Том второй: О Центральном Тибете, Монголии и Бурятии. Ответственный редактор доктор исторических наук Р.Е. Пубаев. Новосибирск, 121-151.

- Эрдэнэбат У., Эрдэнэбат Д.*, 2008. Монгол улсад эртний судлалын үндэсний эрдэм шинжилгээний байгууллага үүсэж хөгжсөн тухай асуудалд. *Acta historica Mongolici* – Монгол Улсын Боловсролын Их Сургууль 9/1, УБ, 5-11.
- Andrews Roy Chapman*, 1932. The New Conquest of Central Asia. A Narrative of the Explorations of the Central Asiatic Expeditions in Mongolia and China, 1921-1930. Vol. 1: Natural History of Central Asia. The American Museum of Natural History. New York.
- Baumann Martin*, 1995. Deutscher Buddhismus. Geschichte und Gemeinschaft. Marburg.
- Gallenkamp Charles*, 2001. Dragon Hunter. Roy Chapman Andrews and the Central Asiatic Expeditions. In Association with The American Museum of Natural History. Foreword by Michael J. Novacek. Penguin Books.
- Goetting Doris*, 2004. Das paedagogische Experiment – Deutschlandjahre mongolischer Schueler, Studenten und Berufspraktikanten 1925-1930. In: Mongolische Notizen. Mitteilungen der Deutsch-Mongolischen Gesellschaft e.V. Nr. 13, Bonn, 18-63.
- Lomborinchen R.*, 1997. The mysterious expulsion of the Roy Chapman Andrews Expedition. Ulaanbaatar.
- Oehmichen Klaus*, 2006. Gebrochene Biografien. Mongolische Autoren, die als Schueler und Praktikanten in Deutschland waren. In: Mongolische Notizen. Mitteilungen der Deutsch-Mongolischen Gesellschaft e.V. Nr. 15, Bonn, 55-67.
- Wolf Serge M.*, 1946. Mongol Delegations in Western Europe 1925-1929. Part II. In: Journal of the Royal Central Asian Society. Vol. 33, London.

РЕЗЮМЕ

У.ЭРДЭНЭБАТ, Д.ЭРДЭНЭБАТ

**ДЭМЧИГИЙН БУДДАРЬ (1894-1939):
БИОГРАФИЯ, ПЕДАГОГИЧЕСКАЯ И ИССЛЕДОВАТЕЛЬСКАЯ
ДЕЯТЕЛЬНОСТЬ**

Впервые в монгольской историографии настоящая статья посвящается изучению биографии, педагогической и научной деятельности одного из выдающихся ученых Монголии 1920-1930-ых гг., - Буддарь багши.

При написании настоящей статьи, нами по возможности были выявлены архивные документы и материалы, позволявшие отразить различные стороны жизни и деятельности Буддарь и его вклад в изучение древней истории и в области педагогики. Нашлись также некоторые материалы, свидетельствующие о его посещении различных стран для изучения иностранных языков.


Жизненный путь Буддарь багши, родившегося в бурятском поселке Цуугэл весьма интересен, так как он с юных лет, невзирая на различные трудности отправился в далекие страны-Китай, Японию, Францию и Германию, чтобы приобрести знания.

Достигнув азы современной науки и научившись русскому, английскому, немецкому, французскому, китайскому и японскому языкам, молодой монгольский интеллигент Буддарь начал трудиться на благо родины в области образования, культуры и науки. Так, в 1926-1927гг., он был поставлен учителем и наставником монгольской молодежи, которая поехала учиться в Германию и во Францию. Буддарь, как один из талантливых ученых Монголии успешно трудился в области образования и с честью выполнял свой долг по распространению знаний среди детей и молодежи.

Однако, к сожалению судьба не позволила ему избежать черной волны политической репрессии в Монголии. Буддарь был арестован 25 сентября 1937 г., и 13 февраля 1939 г., Военной Коллегией Верховного суда СССР был приговорен к высшей мере наказания, что было исполнено через несколько дней - 7 марта. Так, на самом расцвете сил, в 46-ти летнем возрасте, была прервана жизнь одного из замечательных представителей монгольской интеллигенции- Буддарь багши.

В следующий раз, нами будет подготовлена статья о научной деятельности Буддарь.

ХАВСРАЛТ



Д. Буддарь 1925 онд Эндрюсийн экспедицид ажиллаж байхдаа Цагаан нуур хэмээх газраас Шинжлэх Ухааны хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Ж. Цэвээнд орос хэлээр бичсэн захидал

Telegramm Nr. *123456*

Aufgenommen den *22.2.1927*
um *10* Uhr *18* Min. vorm. nachm.
von *Berlin*
durch *...*

Deutscher Reichstelegraph
Berlin-Frohnau Leitung Nr. *...*

Befördert den *...* 46
um *...* vorm. nachm.
in Stg. *...* an *...*
durch *...*

Telegramm aus *Köln* W. den *22.2.* um *10* Uhr *18* Min. vorm. nachm.

*Probleme v. hiesiger Art
ausli. Telegraphie ein tausend
mark adresse Städt. Hospital Köln
Günter Dorn*

1927 оны 2 сарын 22-нд Д. Буддарь багшийн илгээсэн цахилгаан

Telegramm Nr. *...*

Aufgenommen den *27.2.1927*
um *18* Uhr *11* Min. vorm. nachm.
von *Berlin*
durch *...*

Telegraphie des Deutschen Reichs
Berlin-Frohnau Leitung Nr. *...*

Befördert den *...* 44
um *...* vorm. nachm.
in Stg. *...* an *...*
durch *...*

Telegramm aus *Köln* W. den *27.2.* um *18* Uhr *11* Min. vorm. nachm.

*moschee. Gitschma Parichat
beschreiben. für
Bücher*

1927 оны 2 сарын 27-нд Д. Буддарь багшийн бичсэн цахилгаан

		40			
Telegramm Nr. _____ Aufgenommen den 5. 3. 1927 um 16 Uhr 30 Min. vorm. nachm. von _____ durch _____		Telegraphie des Deutschen Reichs  Zeitung Nr. _____ Berlin-Frohnau		Befördert den _____ um _____ in Stg. _____ an _____ durch _____	
Telegramm aus Kuluja		M. den 5. 3. um 15 Uhr 30 Min. vorm. nachm.			
400 Markk Vorri ilayee dalain eldobi sheswignid ilegehn igi sagad kibaru tegurow ergilselku sheregnadi nissore novostei Buddary					

1927 оны 3 сарын 5-нд Д. Буддарь багшийн бичсэн цахилгаан

Blatt № 213		rauenthaler str 9 ischidordji			
abschrift		berlinfrohnau =		37	
Aufgenommen den 12. 3. 1927 um 18 Uhr 41 Min. vorm. nachm. von Funkapparat durch Cchi		Telegraphie des Deutschen Reichs.  Zeitung Nr. _____ Berlin, Haupt-Telegraphenamt		Befördert den _____ um _____ in Stg. _____ an _____ durch _____	
s s moscou 316 36 12 1945 etat allem funk mosk bln					
urğa trebuet obiasnenii dela buddadari stop polutsili ili net dva pisma gde dalai buddadari znak voprosa polutsili pismo buddadari stop potsemu zaderjivaete obiasnenie srotsno telegrafiruite kogda ispolnili nasche pasporiajenie 58 = polpredstvo +					

1927 оны 3 сарын 12-нд Ишдоржоос Буддарь, Далай нарын асуудлаар бичсэн цахилгаан

Moskau
Posolstwo Mongolii
17. 67
Budadari edegerju enedur ireba Dalai albenu mungu
wixsenin unen buget uldexeni ulu toschijamvi
Dalaido bi mungiji schiljigulju abgersen
deutsche usugun bi toschig mii iregulsugei
toschijamu.
Tchidordji
Berlin - Frohnau
Kauenthaer Str. 9. Tchidordji

Москвд суугаа Монголын Элчин сайдын газарт 1927 оны хавар Буддарь,
Далай нарын асуудлаар Германаас Ишдоржийн бичсэн цахилгаан